



**ОЛОН УЛСЫН ГАМШГИЙН  
ТУСЛАМЖ БОЛОН ЭХЭН ҮЕИЙН  
НӨХӨН СЭРГЭЭЛТЭД ҮЗҮҮЛЖ  
БУЙ ДЭМЖЛЭГИЙГ УДИРДАН  
ЧИГЛҮҮЛЭХ БА ЗОХИЦУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАГВАР  
(ТАЙЛБАРЫН ХАМТ)**

**2013 оны 3-р сар**



**International Federation  
of Red Cross and Red Crescent Societies**



**OCHA**



**INTER-PARLIAMENTARY UNION**

Хуулийн загвар

© Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүмүүнлэгийн Үйл Ажиллагааг Зохицуулах Газар мөн Олон Улсын Парламентийн Холбоо, 2013.

**Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо**

P.O. Box 372  
CH-1211 Geneva 19  
Switzerland  
Telephone: +41 22 730 4222  
E-mail: [idrl@ifrc.org](mailto:idrl@ifrc.org)  
Web site: [www.ifrc.org/dl](http://www.ifrc.org/dl)

**Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүмүүнлэгийн Үйл Ажиллагааг Зохицуулах Газар**

United Nations  
Palais des Nations  
8-14 Avenue de la Paix  
CH- 1211 Geneva  
Switzerland  
Tel. +41 22 917 12 34  
E-mail : [ochagva@un.org](mailto:ochagva@un.org)  
Web site: <http://www.unocha.org>

**Олон Улсын Парламентийн Холбоо**

5, chemin du Pommier  
P.O. Box 330  
CH-1218 Le Grand-Saconnex / Geneva  
Switzerland  
Telephone: +41 22 919 41 50  
E-mail: [postbox@mail.ipu.org](mailto:postbox@mail.ipu.org)  
Web site: <http://www.ipu.org>

Хавтасан дээрх зураг: Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо  
- Банкрунгай, Бангкок хотын захын дүүрэг. Зурагчин Феликс Жениет Лафрамбойс

## Гарчиг

Талархал	4
Загвар хуулийн танилцуулга	6
<b>Загвар Хууль</b>	
Загвар хуулийн гарчиг	13
Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлж буй дэмжлэгийг зохицуулах ба удирдан чиглүүлэх тухай хуулийн загвар	13
<b>Загвар хуулийн тайлбар</b>	
Тайлбарын гарчиг	55
Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлж буй дэмжлэгийг зохицуулах ба удирдан чиглүүлэх тухай хуулийн загварын тайлбарууд	59
<b>Лавлах</b>	125

## ТАЛАРХАЛ

ДАНИДА болон Дани Улсын Улаан Загалмай Нийгэмлэгт энэхүү загвар хуулийн туршилтын хувилбарыг боловсруулахад туслалцаа дэмжлэг үзүүлсэнд нь уг төсөл дээр хамтран ажиллагсдын өмнөөс гүн талархалаа илэрхийлье. Мөн Австрали, Канад, Финлянд, Норвеги улсуудын Улаан Загалмай Үндэсний Нийгэмлэгүүд болон засгийн газрууд, Герман, Япон болон Англи улсуудын засгийн газрууд гэх мэт олон олон доноруудад энэхүү хуулийн зүйл заалтуудад үнэлгээ хийсэн семинаруудыг удаа дараа зохион байгуулсанд гүн талархалаа дахин илэрхийлж байна.

Төсөл дээр хамтран ажиллагсад:	Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо (ОУУЗУХСНХ) Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүмүүнлэгийн Үйл Ажиллагааг Зохицуулах Газар (НҮБ-ын ХҮАЗГ) Олон Улсын Парламентийн Холбоо (ОУПХ)
Үндсэн Боловсруулагчид:	Мэри Пикард - хуулийн зөвлөх, Дэвид Фишер - ОУУЗУХСНХ
Хянан тохиолдуулсан:	Элиз Баудот ОУУЗУХСНХ, Виржини Боль НҮБ-ын ХҮАЗГ, Давид Фишер ОУУЗУХСНХ, Карен Жабре ОУПХ, Ноора Баабик ОУПХ, Элиз Москиүни ОУУЗУХСНХ, Ниэлс Скот НҮБ-ын ХҮАЗГ
Хуулийн зөвлөх:	Аллен & Овери LLP, Бейкер болон Маккензи, CMS Камерон Маккена Микрософт, Дэлхийн Гаалийн Байгууллагуудын Хүрээлэн
Судалгаа болон Логистикийн дэмжлэг:	Клеменс Карукс ОУУЗУХСНХ, Лучиа Ципүлло ОУУЗУХСНХ, Надиа Хоури ОУУЗУХСНХ, Каролин Ренолд ОУУЗУХСНХ, Марен Шүльт ОУУЗУХСНХ, Ивона Трускан ОУУЗУХСНХ, Кристина Васала-Кокинаки ОУУЗУХСНХ, Одрей Бэйти ОУУЗУХСНХ

Энэхүү загвар хуулийг боловсруулахад ОУУЗУХСНХ, Засгийн Газрууд, НҮБ болон Төрийн бус байгууллагуудын эрх зүй боловруулагчид, парламентын гишүүд, бүсийн байгууллагууд болон академийн ахлах мэргэжилтнүүд гэх мэт дэлхийн 200 гаруй мэргэжилтнүүдээс санал зөвлөгөө нь авсан бөгөөд дараах уулзалтуудад оролцогчоор уригдаж байсан болно. Үүнд:

- Олон улсын гамшгийн тусламжийн тухай загвар хууль боловсруулах төслийн зөвлөх хороо, 2010 оны 5-р сарын 28, Женев
- Олон улсын гамшгийн тусламжийн тухай хуулийн загварын талаар мэргэжилтнүүдийн уулзалт 2011 оны 5-р сарын 23-24, Женев
- Үндэсний нийгэмлэгүүдийн хуулийн зөвлөхүүдийн уулзалт, 2011 оны 9-р сарын 7, Женев

## Хуулийн загвар

- Олон улсын гамшгийн тусламжийн тухай хуулийн загварын тухай мэргэжилтнүүдийн уулзалт 2011 оны 9-р сарын 19-20, Оксфорд
- Олон улсын гамшгийн тусламжийн тухай хуулийн загварын тухай мэргэжилтнүүдийн уулзалт (Ази номхон далайн бүсд) 2011 оны 9 сар 28-29, Куала Лумпур
- Зүүн хойд Африкт (Horn of Africa) гамшгийн үед олон улсын дэмжлэг тусламжийг зохицуулах болон чиглүүлэх семинар (Зүүн хойд Африкийн бүсд), 2012 оны 4-р сарын 17-19
- “Байгалийн гамшгийн үеийн тусламжийн үйл ажиллагаанд Гаалийн газрын гүйцэтгэх үүрэг” бүсийн семинар (Ази номхон далайн бүсд) 2012 оны 5-р сарын 8-10, Бангкок
- Олон улсын гамшгийн тусламжийн тухай хуулийн загварын талаар мэргэжилтнүүдийн уулзалт (Америк бүсд) 2012 оны 6-р сарын 26, Панам
- Өмнөд америкийн оролцогч талуудын Гамшгийн тухай хуулийн семинар (өмнөд Африкийн бүсд) 2012 оны 10-р сарын 3-4, Габорон
- “Байгалийн гамшгийн үеийн тусламжийн үйл ажиллагаанд Гаалийн газрын гүйцэтгэх үүрэг” бүсийн семинар (Америк бүсд) 2012 оны 11-р сарын 13-15, Санто Доминго
- Загвар хуулийн төсөл ба дараагийн алхамуудын талаар мэргэжилтнүүдийн эцсийн уулзалт. 2012 оны 12-р сарын 10-11, Женев

Бусад хүмүүнлэгийн байгууллагууд болон Женев хотод суугаа төлөөлөгчийн газрууд мөн өөрсдийн саналаа бичгээр ирүүлсэн болно. Энэхүү төсөлд хувь нэмэр оруулсан бүх хүмүүсд талархал илэрхийлье.

*Гол Санаа:*

- *Гамшгийн үед олон улсын дэмжлэгийг зохицуулах нь улам бүр ярвигтай болж байна.*
- *Дотоодын хууль, дүрэм болон журам бүрдсэн байх хэрэгтэй.*
- *Өөрсдийн хууль, дүрэм болон журмыг боловсруулахыг хүсэж буй хууль боловсруулагчид болон албаныханд энэхүү хуулийн загвар нь лавлагаа болох юм.*

## Танилцуулга

Ирээдүйд учирч болзошгүй гамшгийн үед олон улсын тусламж дэмжлэгийг удирдан зохицуулахын тулд энэхүү “Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд үзүүлж буй дэмжлэгийг зохицуулах ба удирдан чиглүүлэх тухай хуулийн загвар”-ыг гамшгийн менежментийн албаныхан мөн хууль тогтоогчид дотоодын хууль, дүрэм болон журмыг боловсруулахдаа лавлагаа болгон ашиглах боломжтой.

Яагаад энэхүү загварыг ашиглах нь зүйтэй вэ? Дэлхийн туршлагаас харахад Олон улсын гамшгийн тусламжийн үйл ажиллагааг зохицуулах нь улам бүр ярвигтай болж байна. Дотоодын хууль эрх зүйн орчингүйгээс гамшигт өртсөн мужид амь нас аврах тусламжийн үйл ажиллагааг эхлүүлэх, зохицуулах болон чиглүүлэхэд тун бэрхшээлтэй байх болно. Аюул гамшиг тохиолдсон үед урьдчилан төлөвлөөгүй, хэт яаран гаргасан төлөвлөгөө нь төрийн хяналтыг сулруулж тохиромжгүй эсвэл чанарын шаардлага хангаагүй тусламжийн бараа орж ирэхэд хүргэдэг. Ихэнхи ийм тохиолдолд тусламж нэн хэрэгцээтэй байгаа үед шаардлаггүй хязгаарлалт үүсгэх, зөв тусламж орж ирэхэд саад тотгор учруулж үргүй зардал гаргахад хүргэдэг юм.\*

Олон улсын гамшгийн тусламж дэмжлэгийн тухай цогц хууль, дүрэм хэрэгжүүлж буй улс орны тоо тун цөөн бөгөөд харамсалтай нь зохицуулалтын түгээмэл асуудлууд тулгарсаар байдаг. Зарим улс орнуудын дотоодын хуулинд аль хэдийнээ багтаасан элементүүдийг энэхүү загварт ашигласан бөгөөд загвар нь одоогийн хэрэгжиж буй хяналт ба удирдан чиглүүлэх системийн үндсэн суурь зарчмыг агуулах юм.

### Загварын хуулийн үүсэл гарал

2007 оны 11 сард Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сарын 30 дугаар зөвлөгөөн хуралдаж (Женевийн конвенцийн оролцогч талууд болон Олон Улсын Улаан Загалмай болон Улаан Хавирган Сар Хөдөлгөөний бүрэлдэхүүнүүдийн цугларалт) Олон улсын гамшгийн тусламж, эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлж буй дэмжлэгийг дотооддоо удирдах чиглүүлэх удирдамжийг (ө.х. олон улсын гамшгийн хариу үйлдлийн хуулийн удирдамж – ОУГХҮХ-ийн удирдамж\*\*) баталсан билээ. ОУГХҮХ-ийн удирдамж нь олон улсын гамшгийн тусламж түгээх үйл ажиллагааны явцад тулгардаг зохицуулалтын түгээмэл асуудлуудад чиглэсэн гамшгийн бэлэн байдлын тухай хууль болон журмуудын боловсруулахад нь засгийн газруудад зөвлөмж болдог. Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо нь долоон жилийн турш олон улс орнуудад хийсэн кейс судалгаа, хуулийн судалгаа, мөн засгийн газрууд болон тусламжийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү ОУГХҮХ-ийн удирдамжийг боловсруулсан билээ.

\* тургарч буй ийм төрлийн хүндрэлтэй асуудлуудыг дэлхийн бусад орнууд хэрхэн шийдвэрлэснийг дэлгэрэнгүй үзнэ гэвэл [www.ifrc.org/dl](http://www.ifrc.org/dl) хаягаар орж олон тооны кейс судалгааны нэгтгэлийг харна уу.

\*\* Олон хэл дээр [www.ifrc.org/dl](http://www.ifrc.org/dl) хаягаар орж унших боломжтой. ОУГХҮХ нэр томъёо нь Олон улсын гамшгийн хариу үйлдлийн хууль, дүрэм ба зарчмууд гэсэн утгыг илэрхийлнэ.

*Гол Санаа:*

- *Загвар хуулийн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөмжүүд дээр тулгуурласан*
- *Ашиглаж болох хууль эрх зүйн нэр томъёог санал болгож байгаа*
- *Олон тооны мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмрийг багтаасан.*



## Хуулийн загвар

2008 оноос эхлэн жил бүрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблей дээр улс орнуудад ОУГХҮХ-ийн удирдамжийг\* ашиглахыг уриалсан тогтоол баталсаар ирсэн билээ. Үүнтэй ижил тогтоолуудыг Дэлхийн Гаалийн байгууллага\*\*, бусад бүсийн байгууллагууд, түүний дотор Америкийн тивийн орнуудын байгууллагууд\*\*\*, Номхон далайн арлын орнуудын форум\*\*\*\* тусган авсан ба Африкийн холбооноос гаргасан гамшгийн менежментийн бодлогын бичиг баримтыг лавлагаа болгон ашигласан юм.

ОУГХҮХ-ийн удирдамж батлагдсаны дараагаар ОУУЗУХСНХ болон түүний гишүүн байгууллагууд 25 орны засгийн газруудад үүнийг хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлсэн. Энэ баримтыг гарснаас хойш өнөөг хүртэл нийт арван нэгэн улс ОУГХҮХ-ийн удирдамж дээр тулгуурлан хууль дүрэм боловсруулсан ба арван хоёр оронд засгийн газартаа батлуулахаар өргөн барьсан байна. Эдгээр техникийн туслалцаа үзүүлэх явцад засгийн газрын албаныхан ОУГХҮХ-ийн удирдамжийг дотоодын хууль, дүрэмд ашиглахад шаардагдах эрх зүйн найрууллага дээр дэмжлэг авах хүсэлтийг удаа дараа гаргаж байсан.

Дээрх хүсэлтүүдийн хариуд Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүмүүнлэгийн Үйл Ажиллагааг Зохицуулах Газар мөн Олон Улсын Парламентийн Холбоо хамтран 2009 онд хуулийн загвар боловсруулах ажлыг эхлүүлсэн билээ. Төслийн хамтрагч талууд нь олон улсын хуулийн байгууллагууд болон институтууд, Аллен & Овери LLP, Бейкер болон Маккензи, CMS Камерон Маккена Микрософт, Дэлхийн Гаалийн Байгууллагуудын Хүрээлэн г.м. олон байгууллагуудаас мэргэжлийн зөвлөгөө авч ажилласан юм. Дээрх байгууллагуудын мэргэжилтнүүд дэлхийн зарим улс орнуудын хэрэгжиж буй хуулинд суурь судалгаа хийж загвар хуулийн төсөл бичхэд зөвлөсөн юм. Женев, Оксфорд ба Куала Лумпур хотуудад мэргэжилтнүүд удаа дараа уулзан загвар хуулийн эхний төсөлд өөрсдийн санал оруулж зөвлөгөөг өгсөн юм.

2011 онд Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сарын 31 дэх удаагийн конференцийг угтан загвар хуулийн туршилтын хувилбар гарсан билээ. Энэ хурлын 7-р тогтоолоор уг олон улсын хуралд оролцогчид (Женевийн конвенцийн оролцогч талууд болон Олон Улсын Улаан Загалмай болон Улаан Хавирган Сар Хөдөлгөөний бүрэлдэхүүнүүдийн цугларалт) төслийн хамтрагч талуудад хуулийн загварыг боловсруулахад тэдний оруулсан хувь нэмэрийг үнэлж, “цаашид энэ хуулийн загварыг лавлах хэрэгсэл болгоход улс орнууд, түншлэгчидэд зөвлөгөө өгөхийг” уриалсан байна. Улс орнуудын оролцоог цаашид чиглүүлэхийн тулд нэмэлт саналуудыг Женев хотод суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас 2011 оны 12 сард авсан бөгөөд үүний хажуугаар 2012 оны 6 сард Нью Йорк хотын эдийн засаг ба нийгмийн зөвлөл дээр уулзалт зохион байгуулсан билээ. Нэмэлт зөвлөлдөх уулзалтуудыг Африк, Ази Номхон далай ба Америк тивд хийсэн бөгөөд төгсгөлийн уулзалтыг Женев хотод зохион байгуулсан юм. 2012 оны 12 сард НҮБ-н ерөнхий чуулга уулзалтны үеэр энэхүү ажлын явцад 67/87 тогтоолоор өндөр үнэлгээ өгсөн бөгөөд загвар хуулийг боловсруулсан төслийн хамтрагч талуудад талархалаа илэрхилсэн байна.

---

\* Сүүлийн үеийн нэр томъёонуудыг НҮБ-ын Ерөнхий Чуулганы 2011 оны 12-р сарын 15-ны өдрийн 66/119 тогтоолын 13 заалтнаас үзнэ үү.

\*\* “Байгалийн гамшгийн тусламжийн үйл ажиллагаанд гаалийн газрын гүйцэтгэх үүрэг” Дэлхийн Гаалийн Байгууллагын тогтоол, 2011 оны 6 сар

\*\*\* Америк тивийн улс орнуудын байгууллагын Ерөнхий Чуулганы 2647 (XLI-O/11) дугаар тогтоол, 2011 оны 06-р сарын 7-ны өдөр

\*\*\*\* Номхон далайн дөчин гурав дахь арлуудын уулзалт, Раратонга, Куук арал, 2012 оны 8-р сарын 28-30

\*\*\*\*\* Гамшгийн эрсдэлийн бууруулах, гамшгийн хариу үйлдэл ба нөхөн сэргээлтийн хэвшмэл орчинг сайжруулах ба зохицуултын асуудлуудад анхаарал хандуулах талаарх 7 дугаар тогтоол, 31C/11/R7 (2011 оны 11 сар)

Засгийн газруудын ахмад мэргэжилтнүүд, ОУУЗУХСНХ, НҮБ болон Төрийн бус байгууллагуудын хууль боловруулагчид, парламентийн гишүүд, бүсийн байгууллагууд болон академийн ахлах мэргэжилтнүүд гэх мэт дэлхийн 200 гаруй мэргэжилтнүүдээс санал зөвлөгөө авч энэхүү загвар хуулийг боловсруулсан юм. 2012 онд загвар хуулийг зарим Үндэсний Нийгэмлэгүүд болон Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо хамтран техник мэргэжлийн тусламжийн төслийн хүрээнд бодит нөхцөл байдалд туршиж үзсэн юм.

*Гол Санаа:*

- *Хуулийн загварыг ашиглан хяналт сайн тавихаас гадна аливаа саатал, хязгаарлалтуудыг багасгах зорилготой.*
- *Сонгогдсон олон улсын байгууллагуудыг хуулийн мэргэжлийн тодорхой дэмжлэгээр хангах шаарлага гардаг.*
- *Мөн эдгээр хамтран ажиллах хуулийн байгууллагуудыг тодорхой стандартыг дагаж мөрдөхийг шаарддаг.*

**Хуулийн загварын зорилгууд**

ОУГХҮХ-ийн удирдамжийн адил Хуулийн загвар нь томоохон хэмжээний олон улсын гамшгийн тусламж түгээх үйл ажиллагааны үед түгээмэл тулгардаг хууль эрх зүйн бэрхшээлүүдийг даван туулахад зориулагдсан юм. Олон улсын дэмжигчид тухайн улс оронд нэвтрэхээс эхлэн тэдний үзүүлж буй тусламж дэмжлэгийг, ялангуяа гамшгийн тусламж ба эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлж буй дэмжлэгийг зохицуулах явцад дээрхи бэрхшээлүүд тулгардаг. Тухайн улс оронд нэвтрэх ба үйл ажиллагаа явуулахад хууль эрх зүйн орчинд үүсдэг бэрхшээлүүдийг нэрлэвэл:

- Гаалийн болон Гадаадын иргэд харъяатын асуудлын хуулиуд нь үүссэн яаралтай гамшгийн нөхцөлд байдалд зохицоогүйгээс олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бараа, гадаадын мэргэжилтнүүд болон тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх процесс удаашрах;
- Тусламжийн бараа болон үйл ажиллагаанд гаалийн татвар болон бусад хураамжуудыг ноогдуулах;
- Гадаад орны нарийн мэргэжлийн мэргэжилтнүүдийг хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөхөд бэрхшээлтэй байх;
- Олон улсын хүмүүнлэгийн байгууллагыг хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөхөд бэрхшээлтэй байх, тухайлбал, тухайн оронд банкинд данс нээх, дотоодын ажилтан хөлсөлж авах, ажлын байр түрээслэх, болон тухайн оронд тохиромжтой үйл ажиллагааг явуулахад хуулийн дэмжлэг үзүүлэх г.м.

Олон улсын тусламжийн чанар болон зохицуулалттай холбоотой дараах бэрхшээлүүд тулгарч болно:

- Шаардлаггүй болон тохиромжгүй тусламжийн бараануудыг импортлох;
- Орон нутгийн удирдлагууд болон бусад тусламж үзүүлэгчидтэй зохицуулалт хийгдэхгүй байх;
- Бүрэн бэлтгэгдээгүй ажилтнуудыг авч ажиллуулах;
- Тусламж хүртэгсэдтэйгээ зөвлөлдөөгүй байх;
- Тухайн орон нутгийн ёс заншилд тохирохгүй зан авир гаргах;



- Өөр шашин шүтлэг буюу улс төрийн намын үзэлийг тулгах.

Гамшигт өртсөн улс оронд түгээх тусламжийн барааг дамжин өнгөрүүлэхэд дараах бэрхшээлүүд үүсч болно:

- Олон улсын хүмүүнлэгийн ажилтан, тусламжийн бараа болон тоног төхөөрөмжийг өөр оронд дамжуулахад тэдгээрийн орох болон гарах явцад саатал учрах;
- Тусламжийн бараа дамжин өнгөрөх явцад гаалийн татвар болон бусад хураамжуудыг ноогдуулах.

#### Гол Санаа:

- Энэхүү загварыг тухайн улс орны нөхцөл байдалд тохируулан өөрчлөх шаардлагатай.
- Улс бүр биеэ даасан ганц хуультай байх нь тийм ч зөв шийдэл болохгүй бөгөөд хэрэглэгжиж буй хууль, дүрэм болон журмуудад энэхүү загварыг нэмэлт өөрчлөлт болгон оруулахыг уриалж байна
- Тухайн улс оронд гамшгийн менежментийн тухай хууль буй гэдэг дээр үндэслэн энэхүү загвар хуулийг гаргав.

#### Загвар хуулийн хэрэглээ

Дэлхий дахинд маш олон төрлийн хуулийн тогтолцоонууд байдаг бөгөөд улс тус бүрт гамшгийн менежментэд хандах хандлаг нь мөн өөр өөр. Энэхүү загвар хуулийн бүлгүүд бүх улс оронд адил үйлчлэх албагүй. Тиймээс тухайн орон нутгийн нөхцөл байдалтай уялдах шаардлагатай. Цаашилбал, зарим улс оронд уг хуулийн загварыг бүтнээр нь хүлээн авч бие даасан хууль гаргах бололцоо байдаггүй.

Дээрх тохиолдлуудад, загвар хуулинд хэрэглэгдэж буй нэр томъёог тухайн оронд хэрэгжиж буй гамшгийн менежментийн журам, гааль, татвар, харилцаа холбоо болон тээвэр г.м. хууль дүрмүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар ашиглаж болох юм. Үүний дагуу уг загварын хажуугийн тэмдэглэлүүдэд ямар хэсгийг тухайн улсын ямар хуулийн аль хэсэгтэй уялдуулан оруулж болохыг харуулсан болно. Хэрэв дээрх “засварлах” аргыг ашиглаж байгаа бол загвар хуулийн гол хэсгүүдийг хооронд нь салгалгүй хадгалахыг зөвлөж байна. Тухайлбал, хууль эрх зүйн тодорхой нөхцөлүүдийг буюу эрх ямбыг бусад хуулиудаар (гааль эсвэл гадаадын иргэн ба харъяатын г.м.) зохицуулж байгаа ч олон улсын талуудын тусгай эрх зүйн эрх ямба эдлэхийг батлах болон цуцлах дэглэмийг нэг хуульд багтаах нь зүйтэй.

Энэхүү загвар хууль нь дотоодын гамшгийн хариу үйлдлийг зохицуулах тогтолцоог тодорхойлохгүй гэдгийг анхаарна уу. Тухайн оронд өөрийн гамшгийн менежментийн хууль байдаг гэж таамаглаж байгаа бөгөөд зарим хуулийн хэд хэдэн зүйлүүд нь дотоодод хэрэглэж буй хууль эрх зүйтэй зөрчилдөх эсвэл давхцах магадлалтай. Түүнчлэн хуулийн загварыг хэрэглэхээс өмнө тухайн улсын хууль дүрмүүдийг сайн судлах нь чухал юм.

## Түлхүүр Тэмдэглэгээ

**Захад байрлах хайрцаган дахь тэмдэглэлүүд** нь хууль санаачлагчид хэрхэн тухайн хэсгийн загвар найруулгыг одоо хэрэгжиж буй төрөл бүрийн хуулиудад нэмэлт өөрчилөлт болгон ашиглаж болох, мөн зарим нөхцөлд дээрх найруулгыг нэмэлт өөрчилөлтөөр бус бие даасан зүйл болгон оруулах нь илүү тохиромжтой болохыг зааж өгнө.

**Загвар хуулинд буй хаалтан доторх текст** нь хуулийн загварыг тусган авч буй орнонд үүссэн нөхцөл байдал, байгуулагын болон хууль эрх зүйн орчноос хамааран өөрт тохируулан ашиглах боломжтой.

**Хаалтанд ташуу үсэгтээр бичигдсэн текст** нь тухайн орны ижил нэршлээр солих (жишээ нь: улсын нэр, үндэсний гамшгийн менежментийн агентлаг гэх мэт) гэсэн утгатай.

**Дөрвөлжин хаалтан доторх текст нь хэрэв ташуу хэлбэрээр бичигдээгүй** байвал өгөгдсөн сонголтуудаас сонголт хийх [жишээ нь: “ерөнхийлөгч/ерөнхий сайд”, “дүүрэг/аймаг”] эсвэл улс орон бүрийн өөрийн сонголтыг ашиглах (заасан хугацааны урт г.м.) боломжтой.

**3-р зүйлд нэр томъёоны тодорхойлолтуудыг** лавлагаа авахад хялбарчлах үүднээс бүх үсгийг томоор бичсэн болно.

Олон улсын гамшгийн тусламж  
болон эхэн үеийн нөхөн  
сэргээлтэнд үзүүлэх  
дэмжлэгийг зохицуулах,  
удирдан чиглүүлэх тухай  
загвар хууль

## Олон улсын гамшгийн туслаж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд үзүүлэх дэмжлэгийг зохицуулах, удирдан чиглүүлэх тухай загвар хууль

Гарчиг

<b>Бүлэг I</b>	<b>Ерөнхий зүйл</b>	<b>17</b>
Зүйл 1	Товч нэр томъёо	17
Зүйл 2	Хуулийн зорилго ба хамрах хүрээ	17
Зүйл 3	Тодорхойлолтууд	18
Зүйл 4	Эрх мэдэл, онцгой эрх, халдашгүй байдал	20
<b>Бүлэг II</b>	<b>Олон улсын гамшгийн дэмжлэгийг эхлүүлэх болон цуцлах</b>	<b>21</b>
Зүйл 5	Олон улсын гамшгийн дэмжлэгийн хэрэгцээг үнэлэх	21
Зүйл 6	Олон улсын гамшгийн дэмжлэгийг хүсэх	21
Зүйл 7	Олон улсын дэмжлэгийг санал болгох ба хүлээн авах	22
Зүйл 8	Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үеийн үе шатууд	23
Зүйл 9	Олон улсын гамшгийн тусламжийг зогсоох	23
Зүйл 10	Эхэн үеийн нөхөн сэргээлтийн олон улсын дэмжлэгийг зогсоох	23
Зүйл 11	(улсын нэр) үндэсний [улаан загалмай/улаан Хавирган сар] нийгэмлэгт үзүүлж буй олон улсын дэмжлэг	24
<b>Бүлэг III</b>	<b>Олон улсын гамшгийн дэмжлэгт бэлтгэх, зохицуулах</b>	<b>25</b>
Зүйл 12	Үндсэн мэдээлэгч байгууллагын эрх үүргийг зохицуулах нь	25
Зүйл 13	Олон улсын гамшгийн дэмжлэгийн бэлэн байдлын ажлын хэсэг	26
Зүйл 14	Нэг сувагт олон улсын чиглүүлэгч баг (SWIFTs)	27
Зүйл 15	Дэмжлэг үзүүлэгч олон улсын талуудын үйл ажиллагааг зохицуулах нь	28

<b>Бүлэг IV</b>	<b>Дэмжлэг үзүүлэгч талуудын ерөнхий үүрэг</b>	<b>29</b>
Зүйл 16	Олон улсын гамшгийн дэмжлэгийн зарчимууд	29
Зүйл 17	Гамшигт өртсөн хувь хүний нэр хүнд, хувийн нууцыг хүндлэх нь	29
Зүйл 18	Бараа болон үйлчилгээний чанар	30
Зүйл 19	Ашиглаж болохгүй бараа, ажиллагаагүй тоног төхөөрөмж болон бусад хаягдлуудыг зайлуулах, устгах нь	30
<b>Бүлэг V</b>	<b>Хууль эрх зүйн ямба эдлэх эрх</b>	<b>31</b>
Зүйл 20	Эрх бүхий талуудад үзүүлэх хууль эрх зүйн ямба	31
Зүйл 21	Дэмжлэг үзүүлэгч зарим талуудад хууль эрх зүйн эрх ямба эдлүүлэх эсэх	31
Зүйл 22	Дэмжлэг үзүүлэгч талууд хууль эрх зүйн ямба эдлэхэд гаргах өргөдөл	32
Зүйл 23	Сонгогдох эрхийг тодорхойлох, баталгаажуулах	32
Зүйл 24	Хууль эрх зүйн ямбыг эдлэх эрхийг цуцлах	33
<b>Бүлэг VI</b>	<b>Эрх бүхий талуудад зориулсан хууль эрх зүйн ямба</b>	<b>34</b>
<b>Хэсэг 1</b>	<b>Олон улсын ажилтан</b>	<b>34</b>
Зүйл 25	Гамшгийн үеийн виз	34
Зүйл 26	Гадаадын мэргэжилтний мэргэшлийг хүлээн зөвшөөрөх	35
Зүйл 27	Гадаадын жолооны үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх	35
Зүйл 28	Нэвтрэх эрх олгох	36
<b>Хэсэг 2</b>	<b>Гамшгийн үед олон улсын бараа, тоног төхөөрөмж нэвтрүүлэх</b>	<b>36</b>
Зүйл 29	Гаалийн хөнгөлөлт ба давуу эрх олгох	36
Зүйл 30	Эрх бүхий талуудын үүрэг	36
Зүйл 31	Гааль уруу төлөөлөгч илгээх нь	36
Зүйл 32	Импортын гаалийн хураамж, татвар болон хязгаарлалтаас Чөлөөлөх нь	36
Зүйл 33	Бичиг баримтанд тавигдах шаардлагыг хялбарчлах нь	37
Зүйл 34	Гаалийн уртасгасан ажлын цагийг гаргах нь	37
Зүйл 35	Хяналт шалгалт ба гаалийн аюулгүй байдал	38
Зүйл 36	Нөөцийн бараа байршуулах тухай зөвшилцөл	38

<b>Хэсэг 3</b>	<b>Олон улсын гамшгийн тусгай бараа болон тоног төхөөрөмжийг чөлөөтэй нэвтрүүлэх ба хязгаарлалт тавих</b>	<b>38</b>
Зүйл 37	Харилцаа холбооны тоног төхөөрөмж	38
Зүйл 38	Эм	39
Зүйл 39	Хүнс	39
Зүйл 40	Импортлосон машин	40
Зүйл 41	Хайгуулч нохой	40
<b>Хэсэг 4</b>	<b>Тоног төхөөрөмж болон ашиглагдаагүй барааны зөвшөөрөгдсөн хуваарилалт</b>	<b>40</b>
Зүйл 42	Тоног төхөөрөмж болон ашиглагдаагүй барааг хуваарилах	40
Зүйл 43	Бараа болон тоног төхөөрөмжийг эргэн экспортлох нь	41
Зүйл 44	Ашиглагдаагүй бараа болон тоног төхөөрөмжийг хандивлах нь	41
<b>Хэсэг 5</b>	<b>Тээвэр</b>	<b>42</b>
Зүйл 45	Тээврийн хэрэгсэлд үзүүлэх хөнгөлөлтүүд	42
Зүйл 46	Тээврийн хэрэгслийн жолооч нарыг нэвтрүүлэх нь	42
Зүйл 47	Тээвэрлэлтийн талаар мэдээлэл өгөх нь	42
<b>Хэсэг 6</b>	<b>Эрх зүйн чадамж ба ажил эрхлэлт</b>	<b>43</b>
Зүйл 48	Олон улсын дэмжигч талуудын эрх зүйн чадамж	43
Зүйл 49	Дотоодын ажилтыг ажилд авах ба халах	43
Зүйл 50	Олон улсын ажилтныг шүүх эрх	44
<b>Хэсэг 7</b>	<b>Эрх бүхий олон улсын дэмжлэг үзүүлэгч талд татвар ноогдуулах нь</b>	<b>44</b>
Зүйл 51	Нэмүү өртгийн татвар (НӨТ) [бусад ижил төстэй татвар]	44
Зүйл 52	Орлогын татвар [бусад ижил төстэй татвар]	45
Зүйл 53	Эзэмшил, өмчийн татвар [бусад ижил төстэй татвар]	46
<b>Хэсэг 8</b>	<b>Валют болон Банк</b>	<b>46</b>
Зүйл 54	Тухайн улсад шаардлагатай хэмжээний мөнгөн хөрөнгө ба валют оруулж ирэхэд үзүүлэх хөнгөлөлт	46
Зүйл 55	Зохимжтой валютын ханш	46



<b>Бүлэг VII</b>	<b>Удирдага, тайлагналт ба шийтгэл</b>	<b>47</b>
Зүйл 56	Дэмжлэг үзүүлэгч талуудыг удирдах	47
Зүйл 57	Дэмжлэг үзүүлэгч талууд харицлага алдах	47
Зүйл 58	Олон улсын хандивласан мөнгөн хөрөнгийн ил тод байдал	48
Зүйл 59	Хэрэгжилтийн жилийн тайлагналт	49
Зүйл 60	Төрийн ажилтныг шийтгэх нь	49
<b>Бүлэг VIII</b>	<b>Олон улсын гамшгийн дэмжлэгийг дамжин өнгөрүүлэх нь</b>	<b>50</b>
Зүйл 61	Дамжин өнгөрүүлэлтийг чиглүүлэх	50
Зүйл 62	Дамжуулан өнгөрүүлэх үе	50
Зүйл 63	Дамжуулан өнгөрүүлэлтэд үзүүлэх хөнгөлөлтүүд	50
Зүйл 64	Гамшгийн дамжин өнгөрөөх виз	51
Зүйл 65	Дамжин өнгөрч буй бараа тоног төхөөрөмж ба тээвэрлэлт	51
Зүйл 66	Дамжин өнгөрүүлэх тээвэр	51
<b>Бүлэг IX</b>	<b>Хэрэгжүүлэлт, шилжилт болон эцсийн зүйл заалтууд</b>	<b>52</b>
Зүйл 67	Дүрмийн хэрэгжүүлэлт	52
Зүйл 68	Хүчингүй болгох ба өөрчилөлт оруулах	52
Зүйл 69	Тусгаар байдал	52
Зүйл 70	Хүчин төгөлдөр болох	52
Зүйл 71	Шилжилтийн зүйл заалтууд	52

*Төслийн тэмдэглэл:*

*Энэхүү загвар хууль нь бие даасан хууль эрх зүйн актаар танилцуулагдаж байгаа ч түүний элементүүдийг төрөл бүрийн хууль дүрэм болон бусад актуудад нэмэлт өөрчилөлтөөр оруулах нь тохиромжтой.*

*Энэ хайрцагуудад дурдагдсан текстүүдийг аль хэсэгтэй уялдан оруулж болохыг тэмдэглэсэн байгаа. Эдгээр нь хуульд нэмэлтээр орж хэвлэгдэх зорилго агуулаагүй болно.*

## **Бүлэг 1. Ерөнхий зүйл**

### **Зүйл 1. Товч нэр томъёо**

а. Энэхүү олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлж буй дэмжлэгийг чиглүүлэх болон зохицуулах хуулийг цаашид “хууль” гэнэ.

б. Мөн “хууль” гэдэгт [жил] оны олон улсын гамшгийн дэмжлэгийн хууль гэсэнг илэрхийлнэ.

### **Зүйл 2. Хуулийн зорилго болон хамрах хүрээ**

а. Энэхүү хууль нь [ .... Улсын үндсэн хуулийн ....-р зүйлийг хэрэгжүүлнэ]. Энэ нь өөрийн [улсын нэр/аймаг/харъя газар] нутаг дэвсгэрт олон улсын гамшгийн дэмжлэгийг өөрийн хүчин чадалд нэмэлтээр авах шаардлагатай гамшгийн эсрэг хариу үзүүлэх үндсэн үүргийн тухай ойлголт дээр тулгуурласан.

б. Энэ хууль нь [улсын нэр] газар нутаг дахь болон [улсын нэрийн] газар нутгаар дамжин өнгөрч буй, олон улсын гамшгийн тусламж дэмжлэгийг чиглүүлэх ба зохицуулахтай холбоотой журам үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгнө.

с. Энэхүү хуулинд, тухайлчилбал

(i) олон улсын гамшгийн тусламжийг чиглүүлэхэд голлон оролцох яам болон газруудын үүрэг хариуцлагыг тогтоох

(ii) олон улсын гамшгийн эсрэг тусламж дэмжлэгийг эхлүүлэх, зохицуулах, зогсоох журам бүрдүүлэх

(iii) Дэмжлэг үзүүлж буй зарим талуудын хууль эрх зүйн эрх ямба эдлэх механизмыг бүрдүүлэх

(iv) Эрх бүхий талуудад эдлүүлэх хууль эрх зүйн эрх ямбыг тодорхойлох

(v) Дэмжлэг үзүүлэгч талуудас үзүүлэх олон улсын гамшгийн тусламжинд тавигдах наад захын стандартууд

(vi) Гамшигт өртсөн улс руу дамжин өнгөрч буй олон улсын гамшгийн тусламж дэмжлэгийг чиглүүлэх

d. Энэ хуулийн зүйлүүд нь [улсын нэр] зэвсэгт мөргөлдөөнт нөхцөл байдал үүссэн тэр газарт нутагт тохиолдож буй гамшигт үйчлэхгүй болно. Эдгээр нөхцөл байдлуудад үзүүлэх олон улсын гамшгийн тусламж дэмжлэг нь [Женевийн конвенцийг хэрэгжүүлэх эрх зүй болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүй] дор удирдагдана.

*Төслийн тэмдэглэл:*

*Энэхүү загвар хуулийн хэсэгүүд бусад хуулиудад нэмэлт өөрчилөлтөөр хэсэгчилэн тусгагдсан бол нэр томъёоллууд тодорхой тусгагдсан байх ёстой бөгөөд тэдгээрийн холбогдох тодорхойлолтуудыг мөн өгөх нь зүйтэй.*

### **Зүйл 3. Тодорхойлолтууд**

Энэхүү хуулийн зориулан:

**“Дэмжлэг үзүүлэгч тал”** гэдэг нь гамшигт өртсөн [улсын нэр]-д дэмжлэг үзүүлж буй олон улсын тал ба дотоодын талыг хэлнэ.

**“Дотооддоо дэмжлэг үзүүлж буй тал”** гэдэг нь [улсын нэр] нутаг дэвсгэрт учирч буй гамшигт хариу үйлдэл үзүүлж буй [улсын нэр] хуулийн дор байгуулагдсан ашгийн бус нэгжийг хэлнэ.

**“Олон улсаас дэмжлэг үзүүлж буй тал”** гэдэг нь [улсын нэр] газар нутаг дахь гамшигт хариу үйлдэл үзүүлж буй болон үзүүлэхээр дамжин өнгөрч буй гадаад улс орон, байгууллага, нэгж болон хувь хүнийг хэлнэ.

**“Дэмжлэг үзүүлж буй засгийн газар”** гэдэг нь [улсын нэр] улсад гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд (өөрийн иргэний буюу цэргийн байгууллагаар дамжуулан) дэмжлэг үзүүлж буй аль ч орны засгийн газрыг хэлнэ.

**“Гамшиг”** гэдэг нь [үндэсний гамшгаас хамгаалах хуулийн ....-р зүйлд тодорхойлсноор] [Зэвсэгт мөргөлдөөний улмаас бус байгаль, осол болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гэнэт болон удаан хугацаанд бүрэлдэн үүсч улмаар нийгмийн тогтвортой үйл ажиллагааг ноцтойгоор алдагдуулан хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон орчин тойронд хүнд, өргөн хүрээний эрсдэл учруулахыг хэлнэ.]

**“Гамшгийн тусламж”** гэдэг нь Гамшигт өртсөн олон нийтийн хүмүүнлэгийн хэрэгцээнд нийцсэн бараа, тоног төхөөрөмж, үйлчилгээнүүд ба аврах ажиллагааг хэлнэ.

**“Дотоодын төрийн бус байгууллага”** буюу “дотоодын ТББ” гэдэг нь хүмүүнлэгийн тусламж, нөхөн сэргээлт болон хөгжлийн төлөө гэсэн мандаттай болон үйл ажиллагаа явуулдаг [улсын нэр] төвийг сахисан сайн дурын ашгийн бус байгууллага болон төрийн бус байгууллагуудыг хэлнэ.

**“Эрх бүхий сонгодсон тал”** гэдэг нь V болон VI бүлэгт заагдсан үйл ажиллагаа явуулах эрх зүйн шаардлага хангасан дэмжлэг үзүүлэгч талыг хэлнэ.

**“Тоног төхөөрөмж”** гэдэг нь бодит зүйлс бөгөөд гадаад орноос ирж буй Гамшгийн тусламж болон нөхөн сэргээлтэнд ашиглагдах зориулалттайгаар бүтээгдсэн гэхдээ дор дурдсан авто тээврийн хэрэгсэл, эмнэлгийн болон харилцаа холбооны төхөөрөмжүүдээр хязгаарлагдахгүй.

**“Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар хөдөлгөөний гадаадын бүрэлдэхүүн”** гэдэг нь гадаад орны үндэстний Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар нийгэмлэгүүд, Олон улсын улаан загалмай ба улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо, Олон улсын улаан загалмай хороог хэлнэ.

**“Гадаадын төрийн бус байгууллага”** гэдэг нь хүмүүнлэгийн тусламж, нөхөн сэргээлт болон хөгжлийн үйл ажиллагаанд чиглэсэн, мандат бүхий, төв байр нь [улсын нэр]-д байрласан байгууллагыг хэлнэ.

**“Бараа”** гэдэг нь гамшигт өртсөн олон нийтэд тусламж үзүүлэх болон нөхөн сэргээлтэнд олгогдохоор зориулагдсан олон улсаас ханган нийлүүлэгдэж буй эд зүйлс юм.

**“Эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэг”** гэдэг нь гамшигт өртсөн олон нийтийг гамшгийн өмнө амьдарч байсан орчинг нөхөн сэргээх, гамшгийг даван туулах болон гамшгийн эрсдлийг бууруулахад зориулагдсан бараа, тоног төхөөрөмж, үйлчилгээ болон олон улсын санхүүгийн тусламжийг хэлнэ.

**“Олон улсын гамшгийн дэмжлэг”** гэдэг нь [улсын нэр] дотоодын дэмжлэг үзүүлэгч талын хүсэлтээр эсвэл нэрийн өмнөөс гадаад орноос оруулан ирж буй; мөн олон улсын дэмжлэг үзүүлэгч талаас үзүүлж буй; болон импортлож буй гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед дэмжлэг тусламжийг хэлнэ.

**“Олон улсын гамшгийн тусламж үзүүлж буй үе”** гэдэг нь уг хуулийн 8 болон 9-р бүлэгт тодорхойлсны дагуу гамшиг болсоны дараах үе юм. Энэ үеэр VI бүлэгт зааснаар эрх бүхий дэмжлэг үзүүлэгч талууд гамшгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаандаа ямар эрх ямбыг эдлэх талаар тайлбарласан байна.

**“Эхэн үеийн нөхөн сэргээлтийн үе”** гэдэг нь уг хуулийн 8 болон 10-р бүлэгт тодорхойлсны дагуу гамшиг болсны дараах үе юм. Энэ үеэр VI бүлэгт зааснаар эрх бүхий дэмжлэг үзүүлэгч талууд эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлэх дэмжлэгийн үйл ажиллагаандаа ямар эрх ямбыг эдлэх талаар тайлбарласан байна.

**“Олон улсын хандивын сан”** гэдэг нь [улсын нэр] засгийн газар, дотоодын дэмжлэг үзүүлэгч талд гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор гадаадын иргэн, байгууллагаас хандивлаж буй сан юм.

**“Олон улсын ажилтан”** гэдэг нь дэмжлэг үзүүлэгч талд ажилд орох үед [улсын нэр] улсад оршин суудаггүй болон харъяалагддаггүй бөгөөд гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд дэмжлэг үзүүлж буй дэмжлэг үзүүлэгч талын сайн дурын идэвхтэн ба ажилтанг хэлнэ.

**“Хууль эрх зүйн эрх ямба”** гэдэг нь Бүлэг VI заасны дагуу эрх бүхийн сонгогдсон талуудад өгч буй тусгай хөнгөлөлт, чөлөөлөлтүүд юм.

**“Дотоодын ажилтан”** гэдэг нь олон улсын гамшгийн тусламжийг улс орны дотоодод хүлээн авах болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд дэмжлэг үзүүлж буй талд ажиллаж буй [улсын нэр] үндэстэн болон харъяа бүхий хувь хүнийг хэлнэ.

**“Үйлчилгээ”** гэдэг нь гамшигт өртсөн олон нийтэд хайгуулын ба аврах үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, мэдээллээр хангах болон хамгаалах зэрэг дэмжлэг үзүүлэгч талуудын зүгээс үзүүлж буй үйлчилгээнүүдийг хэлнэ.

**“Дамжин өнгөрөөх эрх ямба”** гэдэг нь Бүлэг VIII заасны дагуу олон улсын дэмжлэг үзүүлэгч талд өгч буй хөнгөлөлт чөлөөлөлтүүд юм.

**“Дамжин өнгөрөөх эрх ямбын үе”** гэдэг нь уг хуулийн 62 зүйлд тодорхойлсны дагуу өөр оронд гамшиг болсоны дараах үе юм. Энэ үеэр VIII бүлэгт зааснаар эрх бүхий дэмжлэг үзүүлэгч талууд эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлэх дэмжлэгийн үйл ажиллагаандаа ямар эрх ямбыг эдлэх талаар тайлбарласан байна.

**“Тээвэр”** гэдэг нь гамшгийн тусламжийг түгээх, эхэн үеийн нөхөн сэргээлтэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлэгч талын нэрийн өмнөөс агаар, ус, газраар олон улсын ажилтан, бараа, тоног төхөөрөмжийг олон улсын хил дамнуулан тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг хэлнэ.

#### **Зүйл 4. Эрх мэдэл,онцгой эрх, халдашгүй байдал**

Энэхүү хууль нь дэмжлэг үзүүлэгч талын [улсын нэр] улсын бусад хууль болон хамтын гэрээний дагуу олгогдсон эрх мэдэл, тусгай эрх, халдашгүй байдлыг хязгаарлах буюу бууруулахгүй. Мөн үүнд [олон улсын байгууллагын тухай хууль ба дипломат/консулын албаны тухай хууль] ба бусад статус болон дэмжлэг үзүүлэгч тал болон [улсын нэр] хамтын дээд түвшний гэрээнүүд багтана.

Төслийн тэмдэглэл:

Үндэсний гамшгийн менежментийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх дүрмүүдэд энэхүү бүлгийн материалыг ашиглах боломжтой.

## **Бүлэг 2. Олон улсын гамшгийн дэмжлэгийг эхлүүлэх болон цуцлах**

### **Зүйл 5. Олон улсын гамшгийн дэмжлэгийн хэрэгцээг үнэлэх**

а. Том хэмжээний гамшиг болсон даруй [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь [улс/дүүрэг/муж] удирдлагуудтай зөвшилцсөний дүнд анхны хохирол болон хэрэгцээний үнэлгээг хийнэ. Урьдчилсан тооцоо хийсний үндсэн дээр гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд шаардлагатай хэрэгцээг дотоодын хүчин чадлаар бүрэн хангах чадварыг үнэлнэ. Болзошгүй гамшиг эхлэхээс өмнө [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] дээрх шийдлийг өөрийн онцлогт тохируулан өөрчлөх боломжтой.

б. Гамшгийн хэмжээтэй харьцуулахад дотоодын хүчин чадал нь хангалттай бус гэж үзвэл [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь олон улсын гамшгийн тусламж авах хүсэлт нэн даруй гаргахыг [ерөнхийлөгч/ерөнхий сайд]-д зөвлөж санал гаргана.

в. Дээрх зөвлөмж гарсны дагуу [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь [улс/дүүрэг/муж] удирдлагуудтай хамтран нэн шаардлагатай байж болох бараа, тоног төхөөрөмжүүд болон үйлчилгээний жагсаалтыг гаргана. Зүйл 8-ийн дагуу Олон улсын гамшгийн тусламжийн үеийг эхлүүлсэн даруй [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь олон улсын дэмжлэг үзүүлэх чадвартай талуудын жагсаалтыг бэлэн болгоно. Шинээр ирж буй мэдээлэл ба нөхцөл байдал өөрчилөгдөхтэй уялдан дээрх жагсаалтыг шинэчлэх хэрэгтэй.

г. Шинэчлэгдсэн мэдээлэл нөхцөл байдлаас хамааран дотоодын хүчин чадал нь хангалттай бөгөөд олон улсын гамшгийн тусламж шаардлаггүй гэж үзвэл [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] хэзээ ч дахин хянаж, цуцлаж болно.

### **Зүйл 6. Гамшгийн үед олон улсын дэмжлэгийг хүсэх**

а. [ерөнхийлөгч/ерөнхий сайд] олон улсын гамшгийн дэмжлэгийг [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] зөвлөсний дагуу хүсэлт гаргаж болно. Дээрх хүсэлтийг олон улсын бүхий л олон нийтэд эсвэл тухайлчилан нэг олон улсын талд тавьж болно. Нэг талд гэдэг нь хүсэлтийг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Онцгой Үеийн Тусламж Зохицуулах бүсийн байгууллагад гаргана эсвэл холбогдох бүсийн байгууллагад хандана гэсэн үг юм.

б. Хүсэлтийн хамт дараах мэдээллийг хүргүүлнэ:



- (i) Хэрэв мэдээлэл цуглуулах хугацааг хангалттай байгаа бол Зүйл 5-д заасны дагуу [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-ын бэлтгэсэн жагсаалтан дээр үндэслэн гаргасан хүсэмжилж буй дэмжлэгийн төрөл, хүрээг агуулсан мэдээлэл байх
- (ii) Зүйл 7-д заасны дагуу дэмжлэг үзүүлэхийг санал болгож буй олон улсын дэмжлэг үзүүлэгч байгууллагуудад зориулсан үйл ажиллагааны журмуудын талаарх мэдээлэл

### **Зүйл 7. Олон улсын дэмжлэгийг санал болгох нь ба хүлээн авах**

а. (г) дэд зүйлд өөрөөр заагаагүй бол олон улсын дэмжлэг үзүүлэгч тал [улсын нэр] улсад олон улсын гамшгийн дэмжлэгийг үзүүлэхийг санал болгосон тохиолдолд тусламж үзүүлэх боломжтой.

б. Дэмжлэг үзүүлэгч улс, засгийн газар хоорондын хэлэлцээрт байгууллагууд нь [НҮБ оруулан] олон улсын гамшгийн дэмжлэг үзүүлэх саналаа тухайн орны гадаад харилцааны яаманд [албан ёсны [улсын нэр] элчин сайдын газраар дамжуулан] ирүүлнэ. Уг саналд тусламжийн төрөл, хэмжээ, тээвэрлэх арга, тусламж түгээх болон үргэлжлэх хугацаа зэргийг тусгасан байна. Улмаар гадаад харилцааны яам нь дээрх саналын тухай [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] тай зөвшилцөнө. [Холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-аас өгсөн чиглэлийн дагуу гадаад харилцааны яам нь тусламжийг цогцоор нь эсвэл тодорхой хэсгийг хүлээж авна.

в. Дэмжлэг үзүүлэгч улс нь тусламжийг зэвсэгт хүчнээр дамжуулан тараах гэж байгаа бол саналыг [энэ хуулийн доторх дүрмийн дагуу/дэмжлэг үзүүлэгч улсын [улсын нэр] хамтын гэрээ / ойролцоох бүстэй хийсэн гэрээ]-ний дагуу гаргана. [Дээр дурдсан дүрэм/гэрээ]-нд заасан тусгай нөхцлийн дор дээрх дэмжлэгийг бүхлээр нь буюу хэсэгчлэн хүлээн авч болно.

г. Зүйл 6а-д зааснаар олон улсын гамшгийн дэмжлэг авах хүсэлт гаргахад олон улсын дэмжлэг үзүүлэгч тал урьд нь энэ хуулийн бүлэг V зүйлийн дагуу үйл ажиллагаа явуулах эрх бүхий гэж сонгогдсон бол дахин албан ёсоор санал өгөх шаардлаггүй. Хэдий тийм боловч ерөнхий хүсэлтийн нөхцлүүдэд захирагдах ёстой ба тусламж ирэхээс [хамгийн доод тал нь ..... цаг]-ийн өмнө [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-д тусламж дэмжлэгийн төрөл, тоо хэмжээ болон үйл ажиллагаа явуулах хугацаа зэргийг мэдэгдэнэ. Дэмжлэг үзүүлэгч улс буюу засгийн газрын хоорондын байгууллагууд дээрхи мэдээллийг мэдэгдэх шаардлагагүй.

д. Олон улсын гамшгийн дэмжлэг хүссэн ерөнхий хүсэлт гаргаагүй тохиолдолд олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь өөрсдийн сайн дураар тухайн орны гадаад харилцааны яам [холбогдох [улсын нэр] элчин сайдын газраар дамжуулан] олон улсын гамшгийн дэмжлэг үзүүлэхийг хүсэж байгаагаар санал болгож болно. Гадаад Харилцааны яам нь [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-д хамтран зөвшөлцсөний үндсэн дээр түүний үйл ажиллагааны чиглэлийн дагуу бүхлээр эсвэл хэсэгчилэн байдлаар саналыг хүлээж авч болно.

е. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь нөхцөл байдалд олон улсын гамшгийн дэмжлэг үзүүлэх саналыг нэн даруй хүлээн авах болон цуцлах шийдвэрийг гаргана.

### **Зүйл 8. Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үе**

а. Зүйл 6-д заасны дагуу олон улсын гамшгийн дэмжлэг хүссэн хүсэлт гаргамагц эсвэл зүйл 7-д заасны дагуу тавьсан саналыг хүлээн авсан даруй олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үеүд зэрэг эхэлнэ. Энэ үе нь зүйл 9 болон 10-д заасны дагуу цуцлах хүртэл үргэлжилнэ.

б. Бүлэг VI заасны дагуу эрх бүхий байгууллага нь зөвхөн олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үеийн үед хүчинтэй байна.

### **Зүйл 9. Олон улсын гамшгийн тусламжийг зогсоох**

а. Хэрэгцээний дахин үнэлгээ болон бусад мэдээлэл дээр үндэслэн дэмжлэг үзүүлэгч талуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь гамшгийн дэмжлэг авах хэрэгцээ хангагдсан гэж үзвэл [ерөнхийлөгч/рөнхий сайд/гамшгийн менежментийн удирдах хороо]-нд олон улсын гамшгийн тусламжийн үйл ажиллагааг зогсоох өдрийг товлож батлахыг зөвлөнө. Тов гаргахдаа одоогийн тусламжийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх эсэхийг тооцох нь зүйтэй. Уг батламж нь одоо үргэлжилж буй олон улсын гамшгийн нөхөн сэргээх үйл ажиллагаанд нөлөөлөх ёсгүй.

б. Үйл ажиллагааг зогсоох өдрийг дэмжлэг үзүүлэгч талуудад [\*\*\*] өдрийн өмнө зарлана. Хэрэв нөхөн сэргээлтэнд хэрэгцээтэй байгаа бараа, тоног төхөөрөмжүүдийн тухай мэдээллүүдийг хамт хүргүүлж болно.

в. Тусламжийг зогсоосноос үүдэн гарч болох сөрөг үр дагаварыг бууруулах, боломжтой бол хариуцлагыг шилжүүлэн өгөх үүднээс энэ зүйлыг хэрэгжиж эхэлсэн үеэс эхлэн [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] гамшгийн тусламжийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож буй дэмжлэг үзүүлэгч талуудтай зөвшилцөнө.

### **Зүйл 10. Гамшгийн үеийн олон улсын эхэн үеийн нөхөн сэргээлтийг зогсоох**

а. Хэрэгцээний дахин үнэлгээ болон бусад мэдээлэл дээр үндэслэн дэмжлэг үзүүлэгч талуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь гамшгийн дэмжлэг авах хэрэгцээ хангагдсан гэж үзвэл [ерөнхийлөгч/рөнхий сайд/гамшгийн менежментийн удирдах хороо]-нд олон улсын гамшгийн эхэн үеийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг зогсоох өдрийг товлож батлахыг зөвлөнө. Тов гаргахдаа одоогийн тусламжийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх эсэхийг тооцох нь зүйтэй.

б. Үйл ажиллагааг зогсоох өдрийг дэмжлэг үзүүлэгч талуудад [90] өдрийн өмнө зарлана.

в. Энэ зүйлд зааснаар том зарламагц дэмжлэгийг зогсоосноос үүдэн гарч болох сөрөг үр дагаварыг бууруулах, боломжтой бол хариуцлагыг бүрэн шилжүүлэн өгөх талаар [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] гамшгийн эхэн үеийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцож буй дэмжлэг үзүүлэгч талуудтай зөвшилцөнө.

**Зүйл 11. Олон улсаас [улсын нэр] үндэсний [улаан загалмай/улаан хавирган сар] нийгэмлэгт үзүүлэх дэмжлэг**

а. Зүйл 7-д тусгагдсан байдаг боловч [улсын нэр улаан загалмай/улаан хавирган сар] нийгэмлэг нь [загалмай/улаан хавирган хууль болон тунхаг] тусгагдсан үндсэн зарчим болон засгийн газарт нэмэлт хүч болон ажиллах үүргийн дагуу гамшгийн тусламж болон нөхөн сэргээх үйл ажиллагаанд туслуулахаар өөрийн олон улсын улаан загалмай улаан хавирган сар хөдөлгөөний гадаадын түншлэгч байгууллагуудыг хэдийд ч дуудаж болно. Дээрх дэмжлэгийн талаар [холбогдох гамшгийн менежментийн байгууллагад] зайлшгүй мэдэгдэнэ.

б. Зүйл 6-д заагдсан олон улсын дэмжлэгийг хүссэн нэгдсэн хүсэлт зарлагдаагүй байгаа тохиолдолд [улсын нэр улаан загалмай/улаан хавирган сар]-ын хүсэлтийн дагуу [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь олон улсын улаан загалмай улаан хавирган сар хөдөлгөөний түншлэгч орнуудын гамшгийн тусламж дэмжлэг болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд үзүүлэх дэмжлэгийг батлана. Хэрэв тохиромжтой гэж үзвэл дээрх үеийг зүйл 9 ба 10-т заасны дагуу цуцална.

*Төслийн тэмдэглэл:*

*Үндэсний гамшгийн менежментийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх дүрмүүдэд энэхүү бүлгийн материалыг ашиглах боломжтой.*

*Түүнчилэн, энд тусгагдсан байгууллагын тогтолцоо нь улс орон бүрт тохирохгүй байж болно. Эдгээр нь энэ хуулийн хэрэгжүүлэлтийн үндэс болохгүй боловч тухайн улс орны холбогдох бүтэц тогтолцоотой уялдуулахыг зөвлөж байна.*

### **Бүлэг 3. Олон улсын гамшгийн дэмжлэгт бэлтгэх ба зохицуулах**

#### **Зүйл 12. Мэдээлэгч байгууллагын эрх ба зохицуулах үүрэг**

а. [Үндэсний гамшгийн менежментийн хуулийн] дагуу байгуулагдсан [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь засгийн газар болон олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудын хооронд олон улсын гамшгийн дэмжлэгийг зөв зохистой чиглүүлэх, зохицуулах, энэ зүйлийг хэрэгжүүлэх гол харилцаа холбоог дамжуулагч болно. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] НҮБ болон бусад холбогдох бүсийн зохицуулагч бүтцүүдтэй хамтран ажиллах үндсэн тал болно.

б. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь үндэсний, [аймаг/дүүрэг/улс] ба дотоодын засаг захиргааны байгууллагууд зэрэг дэмжлэг үзүүлэгч талуудад гамшгийн үеийн тусламж болон нөхөн сэргээлтийн үед эдлэх үндсэн хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журамд заагдсан эрхийн тухай мэдээллийг өгнө.

в. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь [гамшгийн үеийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед] холбогдох захиргааны байгууллагад олон улсаас гамшгийн тусламж болон нөхөн сэргээлтэнд дэмжлэг үзүүлж буй олон улсын байгууллагуудад хэрэгцээт талбай болон байгууламжийг гарган өгөхийг [хүсэх/тушааж] болно. Эдгээр захиргааны байгууллагууд нь өөрсдийн хуулийн мандатын хүрээнд [зайлшгүй/магадгүй] захирагдана. Хэрэв [хүсэлт/тушаал] нь тухайн хамтран ажиллаж буй байгууллагад их хэмжэний бэрхшээл учруулж болзошгүй бол уг байгууллагын хүсэлтээр хүсэлтийг [зохих дээд албан тушаалтан] дахин хянаж үзнэ.

г. [Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед] [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь олон улсын дэмжлэг үзүүлэгч талын гамшгийн тусламж, нөхөн сэргээлтийг үйл ажиллагааг чиглүүлэх зорилгоор хувь хүнийг сайн дураараа өөрийн зардлаар туслахыг хүсч болно. Үүнд олон улсын дэмжлэг үзүүлэгч талд үзүүлж буй гол үйлчилгээний хураамж татваруудыг бууруулах, цуцлах ба/буюу ажиллах цагийг сунгах г.м. багтана.

д. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь сургалт, дасгал сургуулилтуудад олон улсын зохих дэмжлэг авах боломж байвал түүнд анхаарал хандуулах нь зүйтэй.

### **Зүйл 13. Олон улсын гамшгийн дэмжлэгийн бэлэн байдлын ажлын хэсэг**

а. Олон улсын гамшгийн дэмжлэгийн ажлын хэсэг нь цаашид “ажлын хэсэг” гэж нэрлэгдэх ба [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-ын ерөнхий удирдлаган дор байгуулагдана. Энэ ажлын хэсгийн гол үүрэг нь гамшгийн үед олон улсын гамшгийн дэмжлэг хүссэн тохиолдолд энэхүү хуулийн хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах явдал юм.

б. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дараах төлөөлөгчид орно:

(i) [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]

(ii) [холбогдох яам, агентлаг болон хэлтсүүд]

(iii) [[улсын нэр] улаан загалмай/улаан хавирган сар] нийгэмлэг

(iv) [гамшгийн үед ажилладаг ТББ]; ба

(v) [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-ын уриж оролцуулж болох гэхдээ дор дурьдагдсанаар хязгаарлагдахгүй. Үүнд орон нутгийн [аймаг/дүүрэг/улс] засаг захиргааны албаныхан, үндэсний хамтран ажиллагч талууд, холбогдох НҮБ агентлаг, бүсийн байгууллага, гадаадын ТББ болон олон улсын улаан загалмай улаан хавирган сар хөдөлгөөний бүтцийн орнууд.

в. Ажлын хэсэг нь [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-ын шаардлагын дагуу олон улсын гамшгийн дэмжлэг үзүүлэгч талуудыг удирдан чиглүүлж техникийн зөвлөлгөөг өгнө. Уг үүргийг гүйцэтгэхийн тулд ажлын хэсэг нь:

(i) гамшгийн тусламж болон нөхөн сэргээх дэмжлэгийг оруулах болон удирдан чиглүүлэхтэй холбоотой журам, гарын авлага, удирдамж, төлөвлөгөөг шинэчилэн гаргах

(ii) [улсын нэр]-д хэрэглэгдэж буй хоёр талт, бүсийн болон олон улсын зохицуулах бүтцүүдийг шинэчилэх болон нэгтгэх, улмаар [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-д ижил бүтцийг боловсруулахыг зөвлөх.

(iii) 14 зүйлд заасны дагуу нэг цонх олон улсын зохицуулах багт ажиллахаар яамдаас томиологдсон ажилчдын жагсаалтыг боловсруулж шинэчилж байх. Зүйл 8 дагуу гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудын хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзвэл нэг цонх олон улсын зохицуулах багыг хуралдуулахад туслах,

(iv) энэ хуулийн Бүлэг 4 тусгасны дагуу Гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн чанар стандарт [холбогдох гамшгийн менежментийн байгууллагад боловсруулалт/ боловсруулахад нь зөвлөх]

(v) Энэ хуулийн бүлэг 4 заасны дагуу дэмжлэг үзүүлэгч талуудын хариуцлагын тухай журам, холбогдох бичиг баримтууд болон мэдээллийг боловсруулах

(vi) [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] болон [холбогдох бусад агентлагын] гаргасан олон улсын гамшгийн дэмжлэгтэй холбоотой бусад ажил үүргийг гүйцэтгэх

d. Ажлын хэсэг дараах тохиолдолд хуралдана:

(i) Зүйл 8 дагуу олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийг эхлүүлсэн даруй, зүйл 8 дагуу нэг цонх олон улсын зохицуулах багын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах ба олон улсын гамшгийн дэмжлэгүүдийг зохистой чиглүүлэх тухай журам, гарын авлага хэрэгжүүлэхэд зөвлөх

(ii) Бусад тохиолдолд шаардлагатай бол жилд нэг удаа уулзаж хуулийн хэрэгжүүлэлтийн үндэсний бэлэн байдлыг хянах

#### **Зүйл 14. Нэг сувагт олон улсын чиглүүлэгч баг (SWIFTs)**

а. Энэ зүйлийн дагуу нэг сувагт олон улсын чиглүүлэгч баг байгуулагдах ба гол зорилго нь гаднаас ирж буй мэргэжилтэн, бараа, тоног төхөөрөмж, ба тээврийн тухай хуулийн дагуу тавигдах шаардлагуудыг нэгтгэх, мөн бүлэг 5 тусгасан санал сонгох материалуудыг шуурхай шийдвэрлэх.

б. [Холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь олон улсын гамшгийн дэмжлэгийн бэлэн байдлын ажлын хэсэгтэй хамтран зөвшилцсөний дүнд SWIFTs тоо, гишүүнчлэл, үйл ажиллагаа, удирдлага болон үйл ажиллагааны журмыг энэ хууль болон бусад холбогдох эрх зүйн дагуу гаргана.

в. Зүйл 13 дагуу олон улсын гамшгийн дэмжлэгийн бэлэн байдлын ажлын хэсэг гаргасан нь холбогдох яам, агентлаг төлөөлөгчдөөс бүрэлдэх ба нэрсийг жагсаалтыг боловсруулан шинэчилж байна.

г. Зүйл 8 дагуу олон улсын гамшгийн тусламжийн үеийг эхлүүлсэн даруй SWIFTs нь олон улсын дэмжлэг орж ирэх үндсэн цэг рүү томилогдох ба үүнд үүссэн нөхцөл байдлын дагуу холбогдох онгоцны буудал, усан боомт, хил нэвтрэх цэгүүд г.м. үндсэн цэгүүд юм.



д. Аль нэг хилийн цэгт SWIFTs байхгүй бол тэр газраар олон улсын мэргэжилтэн, бараа, тоног төхөөрөмж болон тээвэр орж ирэх явдлыг зохицуулж буй төрийн албаныхан уг хуулийн зүйлуудын дагуу ажиллана.

**Зүйл 15. Дэмжлэг үзүүлэгч олон улсын талуудын үйл ажиллагааг зохицуулах нь**

а. Үндэсний [аймаг/дүүрэг/улс] албаныхан нь олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудыг өөрсдийн нөөц төлөвлөгөө, гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийг зохицуулах үйл ажиллагаанд уялдуулан [тохиромжтой бол НҮБ онцгой үеийн тусламж зохицуулалтын дэмжлэг болон зөвлөгөөг дуудах] оруулахыг чармайх хэрэгтэй. Түүн дотор гамшигт өртсөн хүмүүсийн хэрэгцээг хангах, аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой зохицуулалтуудыг алдагдуулагүйгээр олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудын үйл ажиллагааг зохицуулах хэрэгтэй.

б. Гамшгийн үеийн тусламж болон нөхөн сэргээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй олон улсын дэмжлэг үзүүлэгч талууд үндэсний [аймаг/дүүрэг/улс] болон дотоодын албаныхантай хамтран ажиллана. Түүний дотор үр дүнтэй, зохицуулалт хийхэд шаардлагатай гамшигт өртсөн хүний хэрэгцээ, байршил, гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээх үйл ажиллагааны цар хүрээ зэрэг өөрт буй бололцоот бүхий л мэдээллүүдийг өгнө.

в. Зүйл 16 тусгагдсанчилан, хангалттай зохицуулалт хийх, өөрсдийн ажлыг хянах үүднээс [улсын нэр] албаныхан олон улсын дэмжлэг үзүүлэгч талыг хүмүүнлэгийн зарчмын дагуу үйл ажиллагаа явуулахыг нь хориглох эрхгүй.

(i) [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-ын тодорхой үйл ажиллагаанд баталсан зохицуулалтанд олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь орон нутгийн болон олон улсын тогтолцоотой хамтран ажиллах ба үүнд [зохих бүсийн байгууллага] болон НҮБ орно.

*Төслийн тэмдэглэл:*

*Бүлэг 4-т буй хууль эрх зүй нь үндэсний гамшгийн менежментийн тухай хуульд болон түүнийг хэрэгжүүлэх дүрмүүдэд хоёрдогч сонголт хэлбэрээр оруулж болно.*

#### **Бүлэг 4. Дэмжлэг үзүүлэгч талуудын ерөнхий үүрэг**

##### **Зүйл 16. Олон улсын гамшгийн дэмжлэгийн зарчим**

а. [улсын нэр] засгийн газар нь өөрийн нутаг дэвсгэрт учирсан гамшигт хариу үйлдэл үзүүлэх үндсэн үүргийг хүлээнэ. Дэмжлэг үзүүлэгч тал нь дотоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй нэмэлт хүч юм.

б. Дэмжлэг үзүүлэгч тал нь тухайн улсын үндсэн хууль, дэмжлэг үзүүлж буй олон нийтийн ёс заншлыг хүндэтгэх үүрэгтэй.

в. Дэмжлэг үзүүлж буй тал нь олон улсын гамшгийн дэмжлэг үзүүлж буй үед хүмүүнлэг, дундыг баримтласан, бие даасан гэсэн зарчмуудыг баримтлана. Зөвхөн хэрэгцээн дээр үндэслэн өөрсдийн зүгээс үзүүлэх гол тусламжийн тодорхойлж гаргах ба доор дурьдсан зүйлүүдээс зайлсхийх хэрэгтэй. Үүнд:

(i) Ялгаварлах, үүний дотор нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, нийгмийн давхарга, бэлгийн сонирхол, хөгжлийн бэрхшээл, нас болон улс төрийн сонирхолд тулгуурлах, гадуурхахыг;

(ii) Гамшгийн хариу арга хэмжээтэй холбогдолгүй дотоодын асуудалд оролцох, тодорхой улс төрийн болон шашин шүтлэгийн байр суурийг эрэлхийх

(iii) өөрсдийн үзүүлж буй дэмжлэгийг ашиглан санхүүгийн ашиг хонжоо хайх эсвэл

(iv) гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлттэй хамааралгүй улс төр, эдийн засаг, цэрэг зэвсгийн тухай чухал мэдээллүүдийг цуглуулах

г. Нэмэлтээр, Төрийн Бус Байгууллага нь өөрийн тусгаар байдлыг хадгалах гэсэн зарчмыг мөрдөнө. Энэ дотроо гадны бодлого болон засгийн газрын хэрэгжүүлэгч байдлаар ажиллахгүй байх.

##### **Зүйл 17. Гамшигт өртсөн хувь хүний нэр хүнд, хувийн нууцыг хүндлэх**

а. Гамшгийн олон улсын дэмжлэгийг үзүүлж буй дэмжлэг үзүүлэгч тал нь Гамшигт өртсөн хувь хүний нэр хүнд, хувийн нууцыг хүндлэнэ. Тусламж хүртэгсэдтэй харилцан зөвшилцсөн гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэд үзүүлж тусламж дэмжлэгийн загвар, хэрэгжүүлэлт, хяналт болон үенэлгээг хийнэ.

б. Дэмжлэг үзүүлэгч тал нь гамшигт өртсөн хувь хүний нууцыг өөрсдийн мэдээллийн санд оруулахад мөн хүндэтгэнэ. Хувь хүний тодорхойлолттой холбоотой мэдээлийг зөвхөн хүмүүнлэгийн тусламж дэмжлэгт хэрэглэх ба давхацсан үйлчилгээ болон залилангаас урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглана.

### **Зүйл 18. Бараа болон үйлчилгээний чанар**

а. Дэмжлэг үзүүлж буй талуудын үзүүлж буй үйлчилгээ, бараа нь гамшигт өртсөн хүмүүсийн хэрэгцээ болон нөхцөл байдалд тохирсон байх ба энэ хууль болон *[улсын нэр]* үндсэн хуульд нийцсэн байна.

б. Энэ зүйлийн (в) дэд хэсэгт тусгагдсанаас бусдаар; дэмжлэг үзүүлэгч талууд нь өөрсдийн бараа болон үйлчилгээнүүд нь СФЕР төслийн “Хүмүүнлэгийн бүлэг, хүмүүнлэгийн тусламжийн стандартийн доод хэмжээ” хангахын тулд өөрсдийн бүхий л бололцоо, нөхцлийг бүрдүүлнэ.

в.Хэрэв үүссэн нөхцөл байдалд СФЕР стандартын чухал зүйлуудыг хэрэгжүүлэх бололцоогүй болон хэрэгжүүлэх оролдлого нь зохимжгүй гэж үзвэл дэмжлэг үзүүлэгч тал нь *[холбогдох гамшгийн менежментийн байгууллага]*-д мэдэгдэл хүргүүлж (б) дэд хэсэгт дурьдсан шаардлагаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж батлуулах боломжтой.

**[Зүйл 18 (б)&(в)-ийн оронд ашиглаж болох хувилбар:** [уг хуулийг хүчин төгөлдөр болохоос *[6 сар]* дотор] дэмжлэг үзүүлэгч талууд нь *[холбогдох гамшгийн менежментийн байгууллага]*-ын боловсруулах техникийн чанарын стандартын дүрмийг даган мөрдөх ба олон улсын гамшгийн дэмжлэг үзүүлэх техникийн ажлын багтай зөвшилцөнө.

### **Зүйл 19. Ашиглаж болохгүй бараа, ажиллагаагүй тоног төхөөрөмж болон бусад хаягдлуудыг зайлуулах, устгах**

Дэмжлэг үзүүлэгч талууд нь гамшгийн үеийн тусламж болон нөхөн сэргээлтэнд хэрэглэхээр импортоор оруулж буй бараа болон тоног төхөөрөмжүүд нь гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд хэрэглэгдэхгүй болох, хаягдал бүтээгдэхүүн үүсгэх, өөрсдийн гаргасан хог хаягдлууд (*аюултай хаягдлууд мөн орно*) зайлуулах, устгах, дахин боловсруулан ашиглах эс бөгөөс аюулгүй, байгальд ээлтэй арга замаар *[улсын нэр]* хуульд заасны дагуу өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

Төслийн тэмдэглэл:

Бүлэг 5-д буй хууль эрх зүй нь үндэсний гамшгийн менежментийн тухай хуульд болон түүний хэрэгжүүлж буй дүрмүүдэд хоёрдогч сонголт хэлбэрээр тавигдаж болно.

## **Бүлэг 5. Хуулийн эрх ямба эдлэх эрх**

### **Зүйл 20. Эрх бүхий талуудад үзүүлэх хууль эрх зүйн ямба**

а. Бүлэг 6-д дурьдагсан хуулийн эрх ямба нь энэ зүйлд тусгагдсан эрх бүхий сонгогдсон талд гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн хугацаанд хүчинтэй. Эс бөгөөс Бүлэг 6 заасны дагуу хуулийн эрх ямба нь 2 үе шатанд ижил хүчин төгөлдөр байна.

б. Уг бүлэгт заагдсан хуулийн эрх ямба нь зүйл 21 дагуу сонгогдсон эсвэл зүйл 22 дагуу сонгогдсоноор батлагдсан олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудад олгогдох бололцоотой байна.

в. 6-р бүлгийн 1-5 хэсгүүдэд дурьдагдсан хуулийн эрх ямбууд нь 21-р зүйлийн дагуу сонгогдсон болон 22-р зүйлийн дагуу сонгогдсоныг тэдний гадаад орноос гамшгийн туслаж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд зориулан авчирсан олон улсын ажилтан, бараа, тоног төхөөрөмж, тээврийг харгалзан үзэж баталсан дотоодын дэмжлэг үзүүлэгч талуудад олгогдоно.

### **Зүйл 21. Дэмжлэг үзүүлэгч тодорхой талуудыг хуулийн эрх ямба эдлэх эрхтэй гэж үзэх**

а. Зүйл 8 дагуу гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийг эхлүүлмэгц дараах (зүйл 22-д заагдсан) олон улсын дэмжлэг үзүүлэгч талууд олон бичиг баримт бүрдүүлэхгүйгээр бүлэг 6-д тодорхойлсон хуулийн эрх ямбыг эдлэнэ. Үүнд:

(i) Дэмжлэг үзүүлэгч улс орон;

(ii) холбогдох засгийн газруудын байгууллага, үүнд Нэгдсэн Үндэсний Байгууллага, Бүсийн байгууллагууд орно;

(iii) *[[улсын нэр] улаан загалмай улаан хавирган сар]* нийгэмлэг ба олон улсын улаан загалмай улаан хавирган сар хөдөлгөөний бүрэлдэхүүн хэсгүүд; ба

(iv) *[холбогдох гамшгийн менежментийн байгууллага]*-н санал болгож буй бусад дэмжлэг үзүүлэгч байгууллага

б. Хуулийн эрх ямба эдлэх эрх олгохыг зохицуулах үүднээс *[холбогдох гамшгийн менежментийн байгууллага]* нь (а)-д дурьдсан дэмжлэг үзүүлэгч талд тэдний хүсэлтээр гэрчилгээ олгоно.

## **Зүйл 22. Хуулийн эрх ямба эдлэх хүсэлт гаргах нь**

а. 21-р зүйлээр эрх авч буй дэмжлэг үзүүлэгч талуудаас бусад талууд нь энэ зүйлийн дагуу хүсэлтээ өгнө. Өргөдөл гаргагч олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь заавал гадаад оронд эсвэл олон улсын хуулинд хуулийн этгээдээр бүртгүүлсэн байх шаардлагатай.

б. Хувийн бизнес эрхлэгчдэд ашиг болон худалдааны сонирхол хайгаагүй зөвхөн тэр тусламжийн үйл ажиллагаанд нь хуулийн эрх ямба эдлүүлж болно.

в. Эрх ямба эдлэх хүсэлтийг гамшиг болохоос өмнө эсвэл дараа нь гаргаж болно. Гамшгийн өмнө хуулийн эрх зүйн эрх ямбыг олгох шийдвэр гарсан тохиолдолд [5 жил]-ийн хугацаанд хүчинтэй байх ба хугацаа дуусмагц шинээр хүсэлтээ гаргах шаардлагатай. Хуулийн эрх ямба нь зөвхөн гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед албан ёсоор үйлчилж эхэлнэ.

г. Хуулийн эрх ямба эдлэхийн тулд өргөдөл гаргаж буй талууд доорхи баримтуудыг бүрдүүлж өгнө. Үүнд:

(i) Дэмжлэг үзүүлэгч олон улсын тал нь гадаад орны эрх зүйн болон олон улсын хуулийн дагуу хуулийн этгээд болох, дэмжлэг үзүүлэгч дотоодын тал нь [улсын нэр] хуулийн дагуу хуулийн этгээд гэдгийг нотлох баримтын албан ёсны хуулбарууд

(ii) Өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүтэн нэр, холбоо барих хаяг болон хэрэв боломжтой бол [улсын нэр]-д орших өөрийн төв байрны хаяг

(iii) Өмнөх туршлага болон одоогийн гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлт үзүүлж чадах хүчин чадлын тухай бичиг баримтууд

(iv) хангалттай хариуцлагын даатгалтайг харуулсан баримт

(v) Бүлэг 4-т дурьдсан үүрэг хариуцлагын дагуу өөрийн байгууллагын туршлага болон үүрэг даалгавар тухай баталгаа гаргах

## **Зүйл 23. Сонгогдох эрхийг тодорхойлох, баталгаажуулах**

а. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] нь зүйл 22 дагуу ирсэн бүх хүсэлтэнд бүлэг 6-д заасан хуулийн эрх зүйн эрх ямба эдлүүлэхээр сонгогдсон гэдгийг баталгаажуулан сертификат олгох, эсвэл хүсэлт батлагдаагүй гэсэн мэдэгдэлийг өгнө.

(i) Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед хүсэлтээ гаргасан талуудад [холбогдох гамшгийн менежментийн байгууллага]-ын хүсэлтийг хүлээн авснаас хойш [тодорхой хугацаа]-аас хэтрүүлэлгүй хариу өгнө.

(ii) Олон улсын гамшгийн тусламжийн үе цуцлагдсаны дараа гэхдээ эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед хүсэлтээ гаргасан талуудад [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] хүсэлтийг хүлээн авснаас хойш [тодорхой хугацаа]-аас хэтрүүлэлгүй хариу өгнө.

б. 22-р зүйлийн дагуу гаргасан өргөдөл нь батлагдсан буюу зүйл 21 заасан шаардлагыг хангасан бол [холбогдох гамшгийн менежментийн байгууллага] тухайн дэмжлэг үзүүлэгч талд бүлэг 6 дагуу хуулийн эрх ямба эдлэх болсоныг батлан сертификат олгоно. Дотоодын дэмжлэг үзүүлэгч талд олгосон сертификат нь бүлэг 6-н 1-5 хэсэгт заасан хуулийн эрх ямба эдэлдэг болохыг илтгэнэ.

в. Энэ зүйлийн дагуу олгогдсон сертификат нь олгогдсон хугацаанаас хойш [5 жил] хүчинтэй байх бөгөөд зүйл 21 болон 22 дагуу шинээр шийдвэрлүүлж шинэчлэгдэж болно.

#### **Зүйл 24. Хуулийн эрх ямба эдлэх эрхийг цуцлах**

Бүлэг 6-д заасан хуулийн эрх ямбыш эдлэх эрхийг нь Дэмжлэг үзүүлэгч талуудын өөрсдийн хүсэлтээр цуцалж болно. Эсвэл энэ хуулийн 57-р зүйлийг зөрчсөн тохиолдолд цуцлагдана.



*Төслийн тэмдэглэл:*

*Бүлэг 6-д заасан зүйлүүд нэг бус харин өөр өөр хуулиудад салангад тусгагдсан бол тэдгээр хуулийн эрх ямба олгох журмыг заасан бүлэг 5-аас лавлагаа авах шаардлагатай.*

*Төслийн тэмдэглэл:*

*Үндэсний гадаадын иргэн харъяатын тухай хуульд 25-р зүйлийг оруулах боломжтой.*

## **Бүлэг 6. Эрх бүхий талуудад олгох хуулийн эрх ямба**

### **Хэсэг 1. Олон улсын ажилтан**

#### **Зүйл 25. Гамшгийн үеийн виз**

а. Хуулийн эрх ямба эдлэх эрх бүхий талын олон улсын ажилтанд гамшгийн үеийн визийг тухайн ажилтанд нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдлын зүгээс ямар нэгэн аюулгүй нөхцөлд олгоно. Гамшгийн визийг [улсын нэр] эхний хугацаанд [3 сар] ямар нэгэн хураамжгүйгээр олгох бөгөөд мөн хураамжгүйгээр дахин [6 сар] хүртэл шаардлагатай бол гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн туршид сунгах боломжтой.

б. Гамшгийн олон улсын тусламжийн үед гамшгийн визийг эрх бүхий талын олон улсын ажилтанд хил нэвтрэх боомтон дээр [эсвэл холбогдох элчин сайдын яаманд материалаа урьдчилан бүрдүүлж өгсөнийн дараа [тодорхой хугацаа]-д шийдвэрлэж] олгоно.

в. Олон улсын гамшгийн тусламжийн үе дууссаны дараа гэхдээ эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед гамшгийн визийн материалыг холбогдох [улсын нэр]-ын элчин сайдын яамнаас [хугацаа]-нд багтаан олгоно.

г. Гамшгийн виз эзэмшигч нь гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед өөрийн ажил олгогчийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж байгаа тохиолдолд оршин суух эсвэл ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй.

#### **[Зүйл 25-ийн оронд ашиглаж болох хувилбар:**

#### **Визний хөнгөлөлт, чөлөөлөлт**

Эрх бүхий талын олон улсын ажилтан нь визэнд тавигдах шаардлага болон түүнтэй холбогдох хураамжаас чөлөөлөгдөнө. Гамшгийн визний хөнгөлөлт эдлэн [улсын нэр]-н хилээр нэвтрэн орсон гамшгийн виз эзэмшигч нь гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед өөрийн ажил олгогчийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж байгаа тохиолдолд оршин суух эсвэл ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй. Олон улсын ажилтан нь ажил олгогч байгуулагтаа ажиллаж гамшгийн олон улсын тусламж болон дэмжлэг үзүүлж буй үед шаардлагатай бол хичнээн ч удаа хилээр нэвтэрч болно. Гэхдээ холбогдох визийг дотоодоо мэдүүлсэн байх шаардлагатай.]

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 26 нь үндэсний гамшгийн менежментийн тухай хуульд эсвэл мэргэжилтний мэргэшлийг хүлээн зөвшөөрөх тухай холбогдох бусад хуулинд хоёрдогч сонголт хэлбэрээр тусгагдаж болно.*

**Зүйл 26. Гадаадын мэргэжилтний мэргэшлийг хүлээн зөвшөөрөх**

а. Гадаадын мэргэшил шаардсан ажилд олон улсын ажилтанг ажиллуулах гэж байгаа бол боловсрол олгосон тухайн улсын гэрчилгээ болон тухайн хүний дээрх ажилд тохирох эсэхийг тодорхойлно.

б.Энэ хуулийг хүчин төгөлдөр болсноос хойш [6 сар] хугацаанд [Холбогдох байгууллага] нь эрх бүхий сонгогдсон талын (а) хэсгийн дагуу баталгаажуулж өгсөний дагуу шууд хүлээн зөвшөөрч болох бүхий [эмнэлгийн мэргэжилтэн, архитектор, инженер болон бусад холбогдох мэргэжил] улс/институтын нэрсийн жагсаалтийг гаргана. Уг жагсаалтыг хамгийн багаар [1 жил бүр] хянаж [цахим] хэлбэрээр нийтэлнэ.

в.[Холбогдох байгууллага] нь эрх бүхий сонгогдсон талаас баталгаажуулж өгсөн мэргэжлийн олон улсын ажилтны баримтууд дээр дурьдсан жагсаалтанд ороогүй улс, институт, мэргэжлээс үүсэлтэй байвал түргэн шуурхай үнэлэх болон хүлээн зөвшөөрөх журмыг гаргана.

г.Энэ зүйлээр гадаадын мэргэжилтэний мэргэшил хүлээн зөвшөөрөгдсөн бол олон улсын эхэн үеийн нөхөн сэргээлтийн үеийг дуустал олон улсын ажилтанг [улсын нэр] ямар нэг мэргэжлийн холбоонд заавал элсэж бүртгүүлэх зэргээс шууд чөлөөлнө.

е. Хэрэв тухайн хувь хүн гэмт хэргийн ёс зүй, мэргэжлийн ёс алдагдаагүй бол энэ зүйлийн дагуу олгосон мэргэшлийн зөвшөөрөл нь [улсын нэр] олон улсын нөхөн сэргээлтийн үе дуустал хүчинтэй байна.

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 27 нь тээвэрлэлтийн хуулинд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.*

**Зүйл 27. Гадаадын жолооны үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх**

[Холбогдох байгууллага] эрх бүхий сонгогдсон талын олон улсын ажилтны гадаадын жолооны үнэмлэхийг гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн хугацаанд түр хэрэглэхийг зөвшөөрнө.

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 28 нь гамшгийн менежментийн хуулинд болон түүнийг хэрэгжүүлэгч дүрэм журмуудад хоёрдогч сонголтоор тусгагдаж болно*

### **Зүйл 28. Нэвтрэх эрх олгох**

Гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед эрх бүхий сонгогдсон талын олон улсын ажилтанг зүйл 15 заасан зохицуулалтын шаардлагын дагуу гамшигт өртсөн газар нутаг дэвсгэрт нэвтрэн орох болон нэрвэгдсэн хүн амд хүрч ажиллахыг зөвшөөрнө. Гэхдээ гамшгийн үеийн үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам болон нийгмийн эрүүл мэндийн хязгаарлалтуудын хүрээнд ажиллах ёстой.

### **Хэсэг 2. Олон улсын гамшгийн тусламжийн бараа, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх**

#### **Зүйл 29. Гаалийн хөнгөлөлт ба давуу эрх олгох**

Цаашид энэ хэсэгт дурьдсаны дагуу [Гаалийн байгууллага] нь эрх бүхий сонгогдсон талын бараа, тоног төхөөрөмжийг шуурхай импортлоход нь давуу эрх олгоно.

#### **Зүйл 30. Эрх бүхий сонгогдох талуудын үүрэг**

Энэ хэсэгт дурьдагдсан давуу эрхийг эдлэхийн тулд эрх бүхий сонгогдсон талууд нь:

а. тэдний импортлох гэж буй бараа, тоног төхөөрөмж нь зөвхөн гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэгт хэрэглэх зорилготой гэдгийг; мөн дотоодын хууль, энэ хууль болон бусад дүрэмд заасан стандартын шаардлагад нийцсэн гэдгийн мэдүүлэх

б. [Гаалийн байгууллага]-аас тавигдах шаардлага болон энэхүү хэсэгт заасны дагуу импортлох гэж буй ачааг савлаж баглан, ангилан, тэмдэглэгээ хийсэн байх

#### **Зүйл 31. Гааль уруу төлөөлөгч илгээх нь**

Олон улсын гамшгийн ачаатай холбоотой асуудлын талаар эрх бүхий сонгогдсон дэмжлэг үзүүлэгч тал [Гаалийн байгууллага]-д өөрөө очих буюу өөрсдийн нэрийн өмнөөс ажиллаж буй хөндлөнгийн байгууллагаар дамжуулж болно.

#### **Зүйл 32. Импортын гаалийн хураамж, татвар болон хязгаарлалтаас чөлөөлөх**

Эрх бүхий сонгогдсон тал эсвэл түүний нэрийн өмнөөс бараа болон тоног төхөөрөмж ачуулсан тал дор дурьдсан давуу талуудыг эдэлнэ:  
а. Гаалийн татвар болон хураамжаас чөлөөлөгдөх  
б. Уг хуулийн 3-р хэсэгт заагдсан тусгай бараа ба тоног

төхөөрөмжүүдийн нэр төрлөөс бусад эдийн засгийн хориг эсвэл хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

г.Гарал үүслийн буюу экспортлосон орны мэдүүлэг байхгүй тохиолдолд ачааг нийгмийн эрүүл мэнд ба аюулгүй байдлын хяналт шалгалтаар дамжин шаардлагатай.

### **Зүйл 33. Бичиг баримтын шаардлагыг хялбарчлах**

[Гаалийн байгууллага] нь:

а. [Гаалийн байгууллага]-д бараа болон тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхэд нь ачуулсан барааны тухай шаардагдах наад захын мэдээллийг агуулсан [хялбарчилсан/урьдчилан өгсөн мэдүүлэг] бүрдүүлж өгөх ба хэрэв шаардлагатай бол тодорхой хугацааны дотор нэмэлт мэдүүлгүүдийг бүрдүүлж өгнө.

б.Эрх бүхий сонгогдсон тал болон түүний төлөөллийн талаас бараа болон тоног төхөөрөмжүүд дээр нэг мэдүүлэг авах

в.Эрх бүхий сонгогдсон тал түүний төлөөллийн талаас барааны мэдүүлэг болон бусад хавсаргах материалуудыг ямар нэгэн хураамжгүйгээр [цахим хэлбэрээр] авах

г.Эрх бүхий сонгогдсон тал болон түүний төлөөллийн талаас ачуулан ирүүлж буй бараа болон тоног төхөөрөмжийг ирсэн даруйд нь нэвтрүүлэх үүднээс мэдүүлэг болон холбогдох баримтыг ачаа ирэхээс өмнө урьдчилан хүлээн авах, шалгах болон бүртгэнэ

д.Эрх бүхий сонгогдсон тал болон түүний төлөөллийн талын ачуулан ирүүлж буй бараа болон тоног төхөөрөмжийн гаалийн бүрдүүлэлт хийх болон ачааг гаргаж авахад онцгой шаардлага гарахгүй бол бичиг баримтын орчуулгаас чөлөөлөх

### **Зүйл 34. Гаалийн уртасгасан ажлын цагийг гаргах нь**

а.Шаардлагатай үед ажлын цагаас гадуур буюу гаалийн газрын ажлын цагаас гадуур эрх бүхий сонгогдсон талууд болон түний төлөөлөгч талуудын ачуулан ирүүлж буй бараа ба тоног төхөөрөмжүүдийг нэвтрэн оруулах үйл ажиллагааг ямар нэгэн нэмэлт төлбөргүйгээр гүйцэтгэнэ.

б.ирж буй ачааг батлахад холбогдох [хэлтэс/яам]-н ажлын цагийг зохицуулах ба шаардлагатай бол зүйл 14 дагуу байгуулагдсан SWIFTs хамтран гаалийн хяналт шалгалт хийх зэрэг хамтарч ажиллана.

### **Зүйл 35. Хяналт шалгалт ба гаалийн аюулгүй байдал**

Зөвхөн олон улсын гамшгийн тусламжийн үед [Гаалийн байгууллага] нь:

а. Эрх бүхий сонгогдсон тал болон түүний төлөөлийн ачуулан ирүүлж буй ачааны мэдүүлгийг шалгах зорилгоор эрсдлийн үнэлгээнд тулгуурлан гаалийн болон холбогдох хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авна.

б. Ирж буй бараа, тоног төхөөрөмжийн бичиг баримтуудыг урьдчилан хүлээн авч эрсдлийн үнэлгээ болон үнэлгээний хүрээг тодойрхойлох хэрэгтэй.

с. Хэрэв боломжтой бол энгийн үед хийгддэг гаалийн шалгалтыг эрх бүхий сонгогдсон тал болон түүний төлөөллийн талын оруулж ирж буй бараа болон тоног төхөөрөмж дээр хийгдэхээс чөлөөлөх. Харин шаардлагатай гэж үзвэл гаалийн шалгалтыг эрх бүхий сонгогдсон талын аюулгүй байдал болон гаалийн ерөнхий аюулгүй байдлын үүднээс хийнэ.

### **Зүйл 36. Нөөцийн бараа байршуулах тухай зөвшилцөл**

Болзошгүй гамшгийн урьдчилсан мэдээлэл болон урьдчилан сэргийлэх зорилгоох [улсын нэр]-ын нутаг дэвсгэрт нөөцийн барааг бүрдүүлэн хадгалах бол энэ хэсэгт заагдсан эрх ямба эдлэх хугацааг [холбогдох удирдлага] эрх бүхий сонгогдсон талтай зөвшилцсөний үндсэн дээр сунгаж болно.

### **Хэсэг 3. Олон улсын гамшгийн тусгай бараа болон тоног төхөөрөмжийг чөлөөтэй нэвтрүүлэх ба хязгаарлалт тавих**

#### **Зүйл 37. Харилцаа холбооны тоног төхөөрөмж**

а. Эрх бүхий сонгогдсон тал нь гамшгийн үеийн дэмжлэг болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн зорилгоор харилцаа холбооны төхөөрөмжийг үндэсний аюулгүй байдал болон нийгмийн хэв журмын дагуу заагдсанаас бусдаар бол ямар нэгэн хязгаарлалтгүйгээр импортлон оруулж ирж болно.

б. Эрх бүхий сонгогдсон талын импортоор оруулж ирэн ашиглах гэж байгаа харилцаа холбооны төхөөрөмжийг ашиглах газар, давтамж, нэрийг мэдээлсний үндсэн дээр [холбогдох харилцаа холбооны байгууллагатай] ашиглалтын хураамж болон зөвшөөрлийн лицензээс чөлөөлнө.

в. Гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэгтэй холбоотой мэдээлэл болон харилцаа холбоонд зориулан ашиглах үелзэл, давтамж, хиймэл дагуул зэргийг зох бүхий сонгогдсон талд дотоодын онцгой үеийн хариу үзүүлэгчидтэй адил эрхээр ашиглахыг зөвшөөрнө.

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 37 нь харилцаа холбооны тухай хуулинд болон түүнийг хэрэгжүүлж буй дүрэмд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.*

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 38 нь эм, эмийн бодисын тухай хуулинд болон түүнийг хэрэгжүүлж буй дүрэмд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно*

**Зүйл 38. Эм**

а.энэ хуулийн шаардлагад нийцэж буй гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд хэрэглэх зорилгоор эрх бүхий сонгогдсон тал нь эм болон эмнэлгийн тоног төхөөрөмжийг импортлон оруулж болно.

б. эм болон эмнэлгийн тоног төхөөрөмж нь гамшигт өртсөн хүний хэрэгцээнд нийцсэн байх, [улсын нэр] [холбогдох эм эмийн бодисын тухай хууль], үйлдвэрлэгч [улсын нэр] хэрэглэхэд хуулийн дагуу зөвшөөрөгдсөн байх шаардлагатай. Хэрэв тийм биш тохиолдолд доор дурьдсан (в)(г) хэсгүүдийн дагуу хандивлагдах зорилготой эмүүд болон эрх бүхий сонгогдсон талын эмнэлгийн үйлчилгээнд шууд хэрэглэгдэх эмүүдийг ялгаж авч үзэх хэрэгтэй.

в.Гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед сонгогдсон талаас эмнэлгийн үйлчилгээнд шууд хэрэглэгдэх эмүүд нь:

(i) Чанарын шаардлагыг хангахын тулд эрх бүхий сонгогдсон тал нь тээвэрлэлт болон хадгалалтын үед байнга зохих нөхцөлд байлгасан байх.

(ii) Зүй бусаар харьцах буюу ашиглах болон гэмтээхээс сэргийлэн хамгаалагдсан байна

г.Хандивлах зорилгоор ашиглагдах эмүүд нь:

(i) [холбогдох эрүүл мэндийн байгууллага]-тай урьдчилж зөвшилцөөгүй л бол орж ирснээс хойш хадгалах хугацаа нь хамгийн багаар 12 сарын дараа дуусахаар байх.

(ii) Хэрэгцээтэй дотоодын хэрэглэгчдэд хүрэх хүртэл эрх бүхий сонгогдсон тал нь чанарыг алдагдуулагүйгээр тохиомжтой нөхцөлд тээвэрлэн хадгалж хүргэх үүрэг хүлээнэ

(iii) Гамшигт өртсөн улсын хэл дээр ойлгомжтой байхаар болон олон улсын нэршил эсвэл ерөнхий нэршлээр, серийн дугаар, тунгийн хэлбэр, хүч, үйлдвэрлэгчийн нэр, савлалтанд буй хэмжээ, хадгалах нөхцөл, дуусах хугацааг гаднах шошго дээр тэмдэглэсэн байна.

**Зүйл 39. Хүнс**

Эрх бүхий сонгогдсон талын импортоор оруулж ирж буй хүнсийг түргэн хугацаанд оруулж ирэхтэй холбоотой дүрэм журмыг [холбогдох хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлага] нь энэ хуулийг хүчин төгс болсноос [6 сар] дотор боловсруулна.

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 39 цаад агуулга нь хүнсний аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлж буй дүрэмд тусгагдаж болно.*

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 40 нь зам тээврийн тухай эсвэл тээврийн хэрэгслийн тухай хуулинд болон түүнийг хэрэгжүүлж буй дүрэмд хоёрдогч сонголтоор тусгагдаж*

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 41-ийг малын эрүүл мэндийн тухай хуулинд оруулж болно.*

*Төслийн тэмдэглэл:*

*Бүлэг 4 зүйлүүд нь гаалийн тухай хуулинд болон түүнийг хэрэгжүүлж буй дүрэмд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.*

#### **Зүйл 40. Импорлосон машин**

[Холбогдох тээврийн газрын удирдлага] эрх бүхий сонгогдсон талын импортоор оруулж ирсэн машинд дотоодын бүртгэл болон бүртгэлийн дугаар олгох хүртэл түр хугацаанд гадаадын бүртгэл болон бүртгэлийн дугаартай явахыг хүлээн зөвшөөрөх.

**[Зүйл 40-ийн оронд ашиглаж болох хувилбар:** [Холбогдох тээврийн газрын удирдлага] нь сонгогдсон талуудын импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгслийн тухайн улс дахь бүртгэл, улсын дугаарыг [түр хугацааны] богино хугацаанд олгоно.

#### **Зүйл 41. Хайгуулч нохой**

Эрх бүхий сонгогдсон талын импортоор түр хугацаанд оруулж ирсэн хайгуулч нохойг энэхүү хууль батлагдсанаас хойш [6 сар] хугацаанд [холбогдох байгууллага]-ын боловсруулсан дүрэм журманд заасан нөхцөл болон шаардлагад нийцсэн тохиолдолд тусгаарлахгүйгээр шууд нэвтрүүлнэ.

#### **Хэсэг 4. Тоног төхөөрөмж болон ашиглагдаагүй барааны зөвшөөрөгдсөн хуваарилалт**

#### **Зүйл 42. Тоног төхөөрөмж болон ашиглагдаагүй барааг хуваарилах**

а. Эрх бүхий сонгогдсон тал нь энэ бүлэгт заасны дагуу татвар, гаалийн хураамж болон бусад хураамжаас чөлөөлөгдсөн бараа болон тоног төхөөрөмжийг гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэг дуусах хүртэлх хугацаанд ашиглагдаагүй бараа болон тоног төхөөрөмжийг өөрийн мэдэлд үлдээх зөвшөөрлийг олгоно.

б. Дээр дурьдсан бараа болон тоног төхөөрөмж нь:

(i) ашгийн бус нэгж бүхий эрх бүхий сонгогдсон талд өөртөө авч үлдэн [улсын нэр]-д хүмүүнлэгийн, хөгжлийн болон энэрэнгүй зорилгоор ашиглагдах эсвэл тараагдах

(ii) зүйл 43 дагуу буцаан экспортлогдох

(iii) зүйл 44 дагуу хандивлагдах

(iv) зүйл 19 дагуу устгагдах боломжтой

в. Мөн дээрх бараануудыг дараах нөхцөлд зарж борлуулах боломжтой:

(i) Эхэн үеийн нөхөн сэргэлтийг цуцалсны дараа

(ii) энэ бүлэгт заагдсан татвар, хураамж бусад хөнгөлөлтүүдийг нөхөн төлсний дараа

#### **Зүйл 43. Бараа болон тоног төхөөрөмжийг буцаан экспортлох**

Энэ бүлэгт заасны дагуу эрх бүхий сонгогдсон талын импортоор оруулж ирсэн ашиглагдаагүй бараа болон тоног төхөөрөмжийг ямар нэгэн татвар, экспортын болон бусад хураамжгүйгээр буцаан экспортлохыг зөвшөөрнө.

а. олон улсын эхэн үеийн нөхөн сэргээлтийг цуцалснаас [3 сар]-ын дотор буцаан экспортыг зохион байгуулна

б. импортоор орж ирсэн бараа болон тоног төхөөрөмж гамшгийн үеийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэгийн зориулалтаар орж ирсэнийг баримтаар батлах шаардлагатай

#### **Зүйл 44. Ашиглагдаагүй бараа болон тоног төхөөрөмжийг хандивлах**

импортоор оруулж ирсэн болон дотоодоос худалдан авсан бараа болон тоног төхөөрөмжийг гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд хэрэгцээгүй болсон бол эрх бүхий сонгогдсон тал нь ямар нэгэн татвар, хураамж, гаалийн татвар болон бусад хураамжуудыг нэхэлгүйгээр дараах тохиолдолд бусад донорууд болон тусламж хүртэгсдэд хандивлаж болно. Үүнд:

а. олон улсын гамшгийн эхэн үеийн нөхөн сэргээлтийг цуцалснаас хойш [3 сар]-аас хэтрэхгүй хандивлах

б. энэ бүлэгт дурьдсан эрх бүхий сонгогдсон тал бараа болон бүлэг барааг импортоор оруулж ирсэн болон худалдан авсан мөн импортлогч болон худалдан авагч, импортлосон болон худалдан авсан хугацааг харуулсан/нотолсон баримтын [холбогдох байгууллагад мөн хуулбарыг хүлээн авагч талд] хамт өгнө.

в. Хандивыг хүлээн авагч нь ашгийн бус сонирхол бүхий эсвэл [улсын нэр] хүмүүнлэгийн байгууллага, [улсын нэр холбогдох засгийн газрын агентлаг] ба хандивыг хүлээн авах хүсэлтэй гэдгээ илэрхийлсэн байх хэрэгтэй.



*Төслийн тэмдэглэл:*

*Бүлэг 5 зүйлүүд дахь агуулагдахуунууд нь тусдаа газрын тээвэр, усан тээвэр болон агаарын тээврийн тухай холбогдох хуулинд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно*

## **Хэсэг 5. Тээвэр**

### **Зүйл 45. Тээврийн хэрэгсэлд үзүүлэх хөнгөлөлтүүд**

Гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд зориулагдсан олон улсын болон дотоодын ажилтан, бараа, тоног төхөөрөмжийг сонгогдсон тал болон түүнийг төлөөлөн тээвэрэлж буй газар, агаар болон усан тээврийн хэрэгсэл нь:

а. агаарын хөдөлгөөн зам гаргах болон газардах г.м. давуу эрх эдлэх

б. холбогдох татвар, хураамж, гаалийн татвар болон энгийн үед [улсын нэр] засгийн газрын нэгжид өгөх бусад хураамжс чөлөөлөгдөх ба дор дурьдсанаар хязгаарлагдахгүй:

(i) Бусад улсын нутаг дээгүүр нисэх, газардах, зогсох, хөөрөх, чиглүүлэлийн хураамж

(ii) сул зогсолт болон эрэг рүү оруулах хураамж

(iii) замын хураамж

в. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийн батламж авах шаардлага үгүй бол буух, бусдын нутаг дэвсгэр дээгүүр нисэх, үлдэх, хөөрөх зэрэгт ямар нэгэн хязгаарлалт, хорио цээрээс чөлөөлөгдөх

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 46 Гадаадын иргэн харъяатын тухай хуулинд тусгагдаж болно*

### **Зүйл 46. Тээврийн хэрэгслийн жолооч нарыг нэвтрүүлэх**

[Холбогдох байгууллага] нь эрх бүхий сонгогдсон байгууллага болон түүний төлөөллийн жолооч, нисгэгч, тээврийн хэрэгслийн хамт олон шуурхай нэвтрэн оруулах, зарцуулагдах цагыг багасгахад чармайлт гаргана.

### **Зүйл 47. Тээвэрлэлтийн талаар мэдээлэл өгөх нь**

Энэ хэсэгт заагдсан хуулийн эрх ямба эдлэхийн тулд эрх бүхий сонгогдсон тал буюу түүний тээвэрлэгч нь:

а. [холбогдох нисэхийн байгууллага]-д нислэгийн маршрут, онгоцыг дуудах нэр, багын гишүүдийн тоо, нислэгийн хуваарь, зорчигчдын жагсаалтыг урьдчилан өгөх ба агаарын хөдөлгөөн удирдах газар болон [холбогдох нисэхийн байгууллага]-аас өгсөн чиглэлийг дагаж мөрдөнө

б. [холбогдох усан тээврийн байгууллага]-д усан онгоц бүрийн очих эрэг, нэр, төрөл, усан онгоц бүрийн бүртгэлийн дугаар, усан онгоцыг удирдаж буй тавцан дээрх ажилчдын тоо, тоног төхөөрөмж, байгууламжууд болон бараа бүтээгдэхүүнүүдийг урьдчилан мэдээлэх ба усан онгоцыг эрэг рүү чиглүүлэн удирдах газар болон [холбогдох байрууллага]-аас өгсөн чиглэлийг дагаж мөрдөнө

## Хэсэг 6. Ажлын байрны эрх зүйн чадамж

### Төслийн тэмдэглэл:

Зүйл 48 тусгагдсан хэсгүүд нь гамшгийн менежментийн тухай хууль, банкны тухай хууль болон хөдөлмөрийн тухай хуулинд тусгагдаж болно. Гадаадын иргэн харъяатын тухай хуулинд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.

### Зүйл 48. Олон улсын дэмжигч талуудын эрх зүйн чадамж

Хуулийн эрх ямба эдлэх статус нь дэмжлэг үзүүлэгч олон улсын талд гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед дасгал сургуулилт хийх болон гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед өөрийн зорилгоо биелүүлэхэд нь [улсын нэр] гамшгийн олон улсын тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үе дэх хуулийн дагуу эрх зүйн чадамжуудыг олгодог. Чадамжуудад нь:

- а.Банкинд данс нээх
- б.Лизинг болон гэрээ хийх
- в.Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө эзэмших болон зарцуулах
- г.Хувь болон нийгмийн сан хүлээж авах болон зарцуулах
- д.Эрх зүйд нийцүүлэн үүрэг гүйцэтгэх ба
- е.энэ хуулийн Зүйл 49 дагуу дотоодын ажилтанг авах болон халах

### Төслийн тэмдэглэл:

Зүйл 49 хөдөлмөрийн тухай хуулинд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.

### Зүйл 49. Дотоодын ажилтанг ажилд авах, халах

а.энэ хуулийн зүйл 4 дагуу, мөн энэ зүйлд заагдсанаас бусдаар, эрх бүхий сонгогдсон бүх дэмжлэг үзүүлэгч олон улсын талууд дотоодын ажилтан авахдаа [улсын нэр] хуулинд захирагдах ба тухайн хүн нь тус [улсын нэр]-д оршин суудаг эсвэл сууж байх ёстой.

б. дотоодын ажилтанг ажилд авахдаа ажил олгогч олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь тус ажилтангийн татвар, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал зэргийг тусад нь бүртгүүлэх шаардлаггүй

с.Хэдийгээр хөдөлмөрийн хуулин дахь зүйлүүдтэй зөрөлдөх ч, эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь :

(i) [улсын нэр]-д хууль ёсоор ажиллах эрхтэй хувь хүнийг ялгаварлан гадуурхалгүйгээр ажилд авах

(ii) хугацаагүй хөдөлмөрийн гэрээ хийхээс илүүтэйгээр богино хугацаатай гэрээ хийж цаашид шаардлагатай бол сунгагдаж болно.

*Төслийн тэмдэглэл:*

*Зүйл 50 хөдөлмөрийн тухай хууль, шүүх болон эрх зүйн журамд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.*

### **Зүйл 50. Олон улсын ажилтныг шүүх эрх**

Хичнээн хөдөлмөрийн хуулийн шийдвэр тогтоол гарсан ч эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талууд олон улсын ажилтантай хийсэн гэрээнд [улсын нэр]-ын төрийн албан хаагч, захиргааны шүүгч ба шүүх нь ямарваа нэг шийдвэр гаргах буюу оролцох эрхгүй. Дээрхи гэрээнд гадаадын болон олон улсын захиргааны болон шүүхийн шийдвэрлэгдэх эрх зүйн тухай хуулийн заалтуудыг агуулсан байна.

### **Хэсэг 7. Эрх бүхий олон улсын дэмжлэг үзүүлэгч талд татвар ноогдуулах нь**

#### **Зүйл 51. Нэмүү өртгийн татвар (НӨТ) [бусад ижил төстэй татварууд]**

а.Олон улсын гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээх үед эрх бүхий сонгогдсон тал гамшгийн тусламж дэмжлэгийг нэмүү өртгийн татвар, үйлчилгээний татвар, бусад ижил татварууд болон төрийн бусад хураамжаас чөлөөлнө. Мөн дээрх үеийн турш эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч тал Нэмүү өртгийн татвар төлөгчөөр бүртгүүлэх шаардлагагүй.

б.Энэ хуулийн эрх ямба эдлүүлснээр орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчидэд эрх бүхий сонгогдсон талд бараа үйлчилгээ нийлүүлэх явцад нь санхүүгийн ямар нэгэн сөрөг үр дагавартай учруулахгүй байх талаар [холбогдох татварын байгууллага] зохих бодит арга хэмжээ авна.

в.Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талд гамшгийн олон улсын тусламжийн ба нөхөн сэргээлтэд зориулсан бараа үйлчилгээний нийлүүлэлтэд НӨТ ноогдуулахгүй. Гэхдээ тус нийлүүлэлтийн үнэлгээ нь [тогтоосон тодорхой доод үнэлгээ]-с илүү байх ёстой. Тиймээс эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талд бараа нийлүүлж буй болон үйлчилгээ үзүүлж буй бэлтгэн нийлүүлэгч НӨТ-ийн тайлан гаргах ба бараа үйлчилгээнийхээ үнэнд НӨТ оруулах шаардлагагүй.

*Төслийн тэмдэглэл:*

*Хэсэг 7 зүйлүүд нь холбогдох татварын хуулинд хоёрдогч сонголтоор тусгагдаж болно.*

**[Зүйл 51-ийн оронд ашиглаж болох хувилбар:**

*НӨТ чөлөөлөх арга*

Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талд гамшгийн олон улсын тусламжийн ба нөхөн сэргээлтэд зориулсан бараа үйлчилгээ нь НӨТ-өөс чөлөөлөгдөнө. Гэхдээ тус нийлүүлэлтийн үнэлгээ нь [тогтоосон тодорхой доод үнэлгээ]-с илүү байх ёстой. Тиймээс эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талд бараа нийлүүлж буй болон үйлчилгээ үзүүлж буй бэлтгэн нийлүүлэгч НӨТ-ийн тайлан гаргах ба бараа үйлчилгээнийхээ үнэнд НӨТ оруулах шаардлагагүй.

*НӨТ ханган нийлүүлэгчгүй арга*

Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талын гамшгийн олон улсын тусламж дэмжлэг болон эхэн үений нөхөн сэртгээлтэнд дэмжлэг болж буй бараа болон үйлчилгээ нь [тогтоосон тодорхой доод үнэлгээ]-ээс давсан бол нэмүү өртгийн татварын талаар асуудал сөхөгдөхгүй. Тиймээс эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талд бараа нийлүүлж буй болон үйлчилгээ үзүүлж буй бэлтгэн нийлүүлэгч ямар нэгэн байдлаар нийлүүлж буй бараанаас үл хамааран НӨТ авахгүй байх, үнийн дүнд оруулахгүй байх]

**Зүйл 52. Орлогын татвар [бусад ижил төстэй татварууд]**

а. Гамшгийн олон улсын тусламж дэмжлэг болон эхэн үений нөхөн сэртгээлтийн үе дэх гамшгийн олон улсын тусламж дэмжлэг болон эхэн үений нөхөн сэртгээлтэнд дэмжлэг болж буй үйл ажиллагаа явуулж буй эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талууд нь татвар ногдуулахгүй. Мөн татвараас чөлөөлөгдөх ба үүний дагуу явуулж буй үйл ажиллагаанаас болон хөрөнгө арвижуулалтаас олсон орлогоос аливаа татвар, хураамж, засгийн газарт төлөх хураамж авахгүй.

б. Гамшгийн олон улсын тусламж дэмжлэг болон эхэн үений нөхөн сэртгээлтийн тухай заалттай холбоотой үйл ажиллагаа явуулж буй эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талын олон улсын ажилтанд тусламжийн үед татвар ногдуулахгүй. Тиймээс аливаа татвар, хураамж, засгийн газарт төлөх хураамж төлөхгүй.

в. Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талын олон улсын ажилтан нь [улсын нэр] оршин суугч биш бөгөөд [улсын нэр]-д хийж байгаа ажилтайгаа холбоотойгоор татвараас чөлөөлөгдөнө. Тиймээс олон улсын ажилтан нь ямар нэгэн татвар, хураамж, төлбөр болон нийгмийн халамжинд хувь нэмэр өгөх, засгийн газарт ямар нэгэн хураамж эсвэл дээр дурьдсантай ижил хөдөлмөр эрхлэлтийн хураамж төлөхгүй.

### **Зүйл 53. Эзэмшил, өмчийн татвар [бусад ижил төстэй татварууд]**

Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талаас гамшгийн олон улсын тусламжийн болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн үед ямар нэгэн татвар, хураамж болон засгийн газарт төлбөр болон бусад ижил төстэй хураамжийг дараахтай уялдан төлөхгүй:

а.Гамшгийн тусамж болон эхэн үеийн сэргээлтийн үед эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талын бүхлээр эсвэл хэсгийг эзэмшиж буй байр, газар, эсвэл байр болон газрын хэсэг

б.Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талын үл хөдлөх хөрөнгө

*Төслийн тэмдэглэл:*

*Хэсэг 8 зүйлүүд нь хоёрдогчоор холбогдох банкны эсвэл санхүүгийн үйлчилгээний тухай хуулинд тусгагдаж болно.*

### **Хэсэг 8. Валют болон Банк**

#### **Зүйл 54. Улс оронд шаардлагатай хэмжээний мөнгөн хөрөнгө ба валют авчрахад үзүүлэх хөнгөлөлт**

Эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч талыг гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлт дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай валют болон санг орж ирэхэд [холбогдох санхүүгийн байгууллага] зохицуулалт хийнэ.

#### **Зүйл 55. Зохимжтой валютын ханшууд**

[Холбогдох санхүүгийн байгууллага] эрх бүхий сонгогдсон олон улсын дэмжлэг үзүүлэгч байгуулагыг гамшгийн үеийн дэмжлэг болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай санг тухайн орны валют руу шилжүүлэхэд эрх зүйн дагуу хамгийн сайн хөврөх ханшийг өгнө.

Төслийн тэмдэглэл:

Бүлэг 7 зүйлүүд нь хоёрдогчоор холбогдох үндэсний гамшгийн менежментийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэгч дүрмүүдэд орж болно.

## **Бүлэг VII. Удирдага, тайлагналт ба шийтгэл**

### **Зүйл 56. Дэмжлэг үзүүлэгч талуудыг удирдах**

а. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага эсвэл гомдол барагдуулах байгууллага] дэмжлэг үзүүлэгч талуудын энэ хуулийн дагуу тухайлбал бүлэг 4 заасан үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих үрэгтэй.

б. [холбогдох гамшгийн менежментийн байгууллага эсвэл гомдол барагдуулах байгууллага] зохицуулах үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлэгч талуудыг гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн хийж буй ажлын тухай тодорхой үечлэлтэйгээр тайлагнахыг шаардана. Энэхүү тайланг олон нийтэд нээлттэй [цахим хэлбэрээр] гаргана

в. Энэ зүйлийн дагуу [холбогдох гамшгийн менежментийн байгууллага эсвэл гомдол барагдуулах байгууллага]-аас гаргасан тайлангийн шаардлага нь дэмжлэг үзүүлэгч талуудад захиргааны нэмэлт ачаалал үүсгэхгүй, хамгийн доод шаардлагад нийцүүлэхээр боловсруулагдана.

### **Зүйл 57. Дэмжлэг үзүүлэгч талууд харицлага алдах**

а.Найдвартай эх сурвалжаас авсан мэдээллийг үндэслэн [холбогдох гамшгийн менежментийн байгууллага эсвэл гомдол барагдуулах байгууллага] аль нэг дэмжлэг үзүүлэгч тал энэ хуулийн дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзвэл тэр дотроо бүлэг 4 заасан үүргийг зөрчсөн гэж үзвэл нэн даруй тухайн дэмжлэг үзүүлэгч талтай холбогдон нэмэлт тайлбар өгөхийг шаардана. Хэрэв хангалтгүй гэж үзвэл [холбогдох гамшгийн менежментийн байгууллага эсвэл гомдол барагдуулах байгууллага] үүргээ биелүүлэггүйг бичгээр мэдэгдэх ба дараах шийдвэрийг гаргана:

- (i) дэмжлэг үзүүлэгч талыг тодорхой хугацаанд өөрийн үүргээ гүйцэлдүүлэх, энэ хугацаанд бүлэг 6 заасан хуулийн эрх ямба эдлэр хүсэлтийг түр цуцлах
- (ii) дэмжлэг үзүүлэгч талын бүлэг 6 заасны дагуу хуулийн эрх ямба эдлэх эрхийг цуцлах
- (iii) Санаатайгаар хуурах, луйвар хийх тохиолдолд хэрэгжүүлэх дүрмийн дагуу торгууль ноогдуулна
- (iv) Ноцтой тохиолдолд [улсын нэр] гамшгийн үед тухайн олон улсын дэмжлэг үзүүлэгч талын гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээх үйл ажиллагааг зогсооно.

б.хэрэв шийдвэр нь (а) болон (iv) дэд бүлгийн дагуу гарсан бол тухайн олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь энэ хуулийн дагуу

тусгаар байх эрх зүй чадамжгүй болон улмаар тухайн улсаас мэдэгдэл өгснөөс хойш [30] хоногийн дотор гарна.

в. энэ зүйлийн (а) (i) эсвэл (а) (ii) дэд зүйлийн дагуу олон улсын дэмжлэг үзүүлэгч талын хуулийн эрх ямбыг цуцлах, зогсоох шийдвэрийг луйврийн болон эрүүгийн хэв шинжээс бусад тохиолдолд эргэн хянаж болно.

г. Дэмжлэг үзүүлэгч тал нь [холбогдох бусад байгууллага болон гомдол барагдуулах байгууллага]-ын гаргасан сөрөг шийдвэрийг давж заалдах эрхтэй.

д. энэ зүйл нь [улсын нэр] хуулийн дагуу олон улсын дэмжлэг үзүүлэгч тал эсвэл олон улсын болон дотоодын ажилтны холбогдсон эрүүгийн зөрчилд оноосон шүүхийн шийдвэрт саад учруулахгүй

*Төслийн тэмдэглэл:*

*Олон улсын хандивласан мөнгөн хөрөнгийн ил тод байдал нь одоогийн хэрэгжиж буй гамшгийн менежментийн, санхүүгийн гүйлгээний ба болон дотоодын төрийн бус байгууллагын эрх зүйд тусгагдсан байж болно.*

**Зүйл 58. Олон улсын хандивласан мөнгөн хөрөнгийн ил тод байдал**

а. [улсын нэр] засгийн газрын хүлээн авсан олон улсаас гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд зориулан хандивласан мөнгөн тусламжийг [засгийн газрын холбогдох байгууллага, нэгж] зөвшөөрөх ёстой. Уг мөнгөн тусламжийг:

(i) [гамшгийн менежментийн хуулийн дагуу байгуулагдсан гамшгийн менежментийн санд байршуулах ба оруулах журмыг дүрмээр баталж гаргана]

(ii) Олон улсын гамшгийн тусламжийн үе дууссанаас хойш [6 сар] мөн эхэн үеийн дэмжлэгийн үеийг зогссоноос [3 сарын дотор] [холбогдох байгууллага] аудитын шалгалт хийнэ. Энэхүү аудитын дүнг [цахим хуудсанд] олон нийтэд ил тод гаргана.

б. Олон улсаас хандивласан мөнгөн тусламжийг гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээх зориулалтаар дотоодын дэмжлэг үзүүлэгч тал хүлээж авч байгаа бол:

(i) Гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтэнд зориулсан данс нээж байршуулна

(ii) Олон улсын гамшгийн тусламжийн үе дууссанаас хойш [6 сар] мөн нөхөн сэргээлтийн үеийг зогсоосноос хойш [3 сар]-ын дотор [холбогдох байгууллага] хөндлөнгийн аудитын шалгалт оруулна. Аудитын үр дүнг [холбогдох удирдлага]-д тайлагнах ба олон нийтэд нээлттэй [цахим хувилбараар] гаргана.

**Зүйл 59. Хэрэгжүүлэлтийн жилийн тайлагналт**

[Холбогдох гамшгийн менежментийн удирдлага] нь парламентийн [холбогдох хороо]-нд энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ болон гамшгийн бэлэн байдлыг хангахад ажлуудыг жил бүр тайлагнана.

**Зүйл 60. Төрийн ажилтныг шийтгэх нь**

[Улсын нэр] төрийн албаныхан энэ хуулийн дагуу хүлээсэн үүргээ үл биелүүлвэл, [нийгмийн ёс журмын дагуу сахилга бат ба/эсвэл] [тоо] хүртэл хэмжээний торгууль төлнө. Иргэний буюу эрүүгийн хариуцлагаас ангид бусад хуулийн дагуу төрийн албан хаагчдын гаргасан үйлдэл дутагдлыг мөн л хамруулж болно.



Төслийн тэмдэглэл:

Бүлэг 8 зүйлүүд нь хоёрдогчоор холбогдох гаалийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэгч дүрмүүдэд орж болно.

## **Бүлэг VIII. Гамшгийн үеийн олон улсын дэмжлэгийг дамжин өнгөрүүлэх**

### **Зүйл 61. Дамжин өнгөрөлтийг чиглүүлэх**

Өөр улсад тохиолдож буй гамшгийн үед олон улсын дэмжлэг шаардагатай үед [холбогдох гааль, гадаадын иргэд харьяатын, тээврийн алба] өөрийн газар нутаг дээгүүр гамшгийн олон улсын дэмжлэг үзүүлж буй олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудын олон улсын ажилтан, бараа, тоног төхөөрөмж, тээврийг энэ зүйлд заасны дагуу гамшигт өртсөн нутаг дэвсгэр рүү хурдан шуурхай тээвэрлэх, дамжин өнгөрүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

### **Зүйл 62. Дамжин өнгөрүүлэх үе**

а. гамшигт өртсөн орны удирдлагаас саналыг нь авсны дараа гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэг хэрэгцээтэй болох; олон улсын мэргэжилтэн, бараа, тоног төхөрөмжийг өөрийн нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэх нь гарцаагүй гэвэл [холбогдох байгууллага] дамжин өнгөрөлтийн хөнгөлөлтийн үеийг эхлүүлнэ.

б. цаашид дамжин өнгөрүүлэх шаардлага байхгүй гэсэн тохиолдолд [холбогдох удирдлага]-аас дамжин өнгөрүүлэх хөнгөлөлтүүдийг цуцлах хүртэл дамжин өнгөрүүлэх үе үргэлжлүүлнэ.

в. дамжин өнгөрүүлэх үеийг цуцлах өдрийг товлосон хугацаанаас [цаг хугацаа]-ны өмнө олон улсын дэмжлэг үзүүлэгч талуудад мэдэгдэнэ.

г.энэ зүйлд заагдсан дамжин өнгөрүүлэх хөнгөлөлтүүд нь зөвхөн дамжин өнгөрүүлэх хугацаанд хүчинтэй байна.

### **Зүйл 63. Дамжуулан өнгөрүүлэлтэд үзүүлэх хөнгөлөлтүүд**

а. (б)-д заасны дагуу тухайн олон улсын дэмжлэг үзүүлэгч тал нь гамшигт өртсөн улс руу гамшгийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн зорилгоор дамжуулан өнгөрүүлэх гэж буй олон улсын мэргэжилтэн, бараа болон тоног төхөөрөмжийг [улсын нэр] нутагаар дамжуулан өнгөрүүлж буй мэдүүлснээр хөнгөлөлт эдлэх эрхтэй.

б. үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс буюу луйврийн шинж чанар илэрвэл [холбогдох байгууллага] олон улсын дэмжлэг үзүүлэгч талд дамжуулан өнгөрүүлэх хөнгөлөлтийг өгөхөөс татгалзаж болно. Дамжуулан өнгөрүүлэх хөнгөлөлт үзүүлэхээс татгалзаныг энэхүү хуулийн 57 зүйлд заасны дагуу мэдэгдэнэ.

#### **Зүйл 64. Дамжин өнгөрөх виз**

Эрх бүхий сонгогдсон талын олон улсын ажилтан нь гамшигт нэрвэгдсэн улс орон руу [улсын нэр]-аар дамжин нэвтрэх үед гамшгийн үеийн [нэг удаагийн орох гарах] визийг хилийн боомтон дээр ирэхэд нь олгоно. Гэхдээ тухайн хувь хүн үндэсний аюулгүй байдал болон нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдалд ямар нэг асуудал үүсгэхгүй гэсэн тохиолдолд олгоно. Гамшгийн дамжин өнгөрөх визийг ямар нэгэн хураамжгүйгээр олгоно.

**[Зүйл 64-ийн оронд ашиглаж болох хувилбар:** Эрх бүхий сонгогдсон талын олон улсын ажилтан нь гамшигт нэрвэгдсэн улс орон руу [улсын нэр]-аар дамжин нэвтрэх үед [улсын нэр] газар нутгаас [тоо] хоногийн дотор гарна гэсэн нөхцлийн дор гамшгийн визийг мэдүүлэхэд шаардлагатай баримт бичиг, холбогдох хураамж болон төлбөрөөс чөлөөлөгдөнө.]

#### **Зүйл 65. Дамжин өнгөрч буй бараа ба тоног төхөөрөмж**

Эрх бүхий сонгогдсон тал нь гамшигт өртсөн орон уруу илгээх бараа, тоног төхөөрөмжийг гаалийн дамжуулах, дамжуулан өнгөрүүлэх газарт байрлуулах үед Бүлэг 4-н 2 болон 4 хэсгүүдэд тусгагдсан зүйлүүд үйлчилнэ.

#### **Зүйл 66. Дамжин өнгөрөх тээвэр**

Гамшигт өртсөн оронд гамшгийн үеийн тусламж болон эхэн үеийн нөхөн сэргээлтийн дэмжлэгийн ачааг [улсын нэр]-ын газар, ус болон агаарын хилээр дайран өнгөрөн тээвэрлэж буй олон улсын дэмжлэг үзүүлэгч талын газрын, усан болон агаарын тээврийн хэрэгслүүдэд бүлэг 5 хэсэг 5 зүйлүүд үйлчилнэ.

## **Бүлэг IX. Хэрэгжүүлэлт, шилжилт болон эцсийн зүйл заалтууд**

### **Зүйл 67. Дүрмийн хэрэгжүүлэлт**

Зааварчлагаа шаардлагатай эсвэл өгөх боломжтой бүхий л асуудлуудтай холбоотой; мөн энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эсвэл энэ хуулийн дагуу өгөгдөх эрх, үйл ажиллагаа, үүрэг болон бүрэн эрхийг үйлчилж эхлүүлэхтэй холбогдуулан [холбогдох байгууллага] дүрмүүдийг гаргана.

### **Зүйл 68. Хүчингүй болгох, өөрчилөлт оруулах**

[Холбогдох хуулиудын нэр ба хэсгүүд/ [#] дугаар хуваарьт жагсаасан эрх зүйн хуулийн зүйлүүд нь][өдөр]-өөс эхлэн хүчингүй болно.

### **Зүйл 69. Тусгаар байдал**

Энэ хуулийн зүйл бүр нь биеэ даасан зүйл юм. Хэрэв энэ хуулийн аль нэг зүйл нь хууль бус болох, хүчингүй, даган мөрдөх нөхцөлгүй болбол бусад зүйлүүдэд нөлөөлөхгүй.

### **Зүйл 70. Хүчин төгөлдөр болох**

Энэхүү хууль нь [огноо / [албан ёсны хэвлэлийн нэр]-д нийтлэгдсэний [бүхэл оронтой тоо] өдрийн дараа] хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

### **Зүйл 71. Шилжилтийн/завсрын зүйл заалтууд**

[Холбогдох удирдлага] нь энэ хуулийн хэрэгжүүлэлтэнд шаардлагатай шилжилтийн/завсрын, түр зуурын болон хэмнэлтийн үүднээс зүйл заалтуудыг оруулж болно.